



“ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ” ОНӨААТҮГ

БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

/Хамрах хугацаа: 2023.01.02-2023.12.28/



УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

АГУУЛГА

Д/д	Үзүүлэлт	Хуудасны дугаар
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ		
1.1	Нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, үр дүн	1-10
1.2	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн	10-12
1.3	Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилт, үр дүн	12-13
1.4	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал, үр дүн	13-20
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ		
2.1	Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт	20-21
2.2	Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гарсан төлөвлөлтийн баримт бичгүүд, түүний биелэлт, үр дүн	21-33
2.3	Хууль эрх зүйн ажлын хэрэгжилт, үр дүн	33-37
2.4	Худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн	38
2.5	Үйл ажиллагааны зардлыг бууруулах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, өр авлагыг барагдуулах, эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх талаар хийсэн ажил, үр дүн	38-39
2.6	Тайлант оны төсөв төлөвлөгөөнд тусгагдаагүй шинээр санаачилж хийсэн бүтээлч ажил, чанар үр дүн	39-40
2.7	Хөрөнгө оруулалтын хүрээнд хийсэн ажил	40-41
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ		
3.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлсэн ажлын үр дүн	41-42
3.2	Гадаад харилцааны чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл	43-51
3.3	Ажилчид, албан хаагчдын ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хариуцлага сахилгыг өндөржүүлэх, ёс зүйг сахих чиглэлээр санаачилж хийсэн ажил, үр дүн	52-60
3.4	Мэдээллийн технологийн ололтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, үйлчилгээг шуурхай болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй ажил, үр дүн	60-62
3.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд	62-66
3.6	Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны хэрэгжилт	66-74

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

1.1 НИЙСЛЭЛ, ХОТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨЖ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

1.1.1 “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах” ажил:

2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан ХБХГ/ХТСИ-А/860-1 дугаартай гэрээний дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан дуусгаж 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан.


Засгийн газарт өргөн барих тогтоолын төсөл хавсралт материалуудыг бэлтгэн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тогтоолын төсөлд яамдуудаас санал авах ажлыг Хот байгуулалт, хөгжлийн газар, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран гүйцэтгэсэн. 2022 оны 06 дугаар сараас 10 дугаар сарын хооронд яамдуудын санал зөвлөмжийг тусган ажилласан ба шинээр томилогдсон сайд нараас санал авсан. Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамдуудаас өргөн мэдүүлэх зөвшөөрөл авах хугацаанд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд “Шинэ тойрог зам”, “Сэлбэ сэргэлт”, “Тусгай замын их багтаамжийн автобус төсөл /BRT/ төслүүдийг харилцан уялдуулж нэмэлтээр тусгуулах ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хамтарсан 94/А/443 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар батлагдсан.

Захирамжийн дагуу БХБЯамны Дэд Сайдад төлөвлөгөөний төслийг танилцуулж, ажлын хэсгийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд тусгасны дагуу одоогийн байдлын суурь мэдээллийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган ажилласан.



Зураг-1.1

2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2021/175 дугаартай гэрээний дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд 2040 оны ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.



Зураг-1.2

1.1.2 Улаанбаатар хотын “Шинэ төв” дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажил:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/524 захирамжийг үндэслэн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт, хөгжлийн газартай байгуулсан №НХААГ 21/175/2 дугаартай гэрээ, №2021/04 дугаартай зургийн даалгаврын дагуу “ШИНЭ ТӨВ” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах 189 га (Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо) ажлын зураг төслийн эцсийн тайланг Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай материалуудыг боловсруулж улсын магадлалын дүгнэлт гаргах ажлын хэсгээр хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулан захиалагч байгууллагад хүлээлгэн өгөв.



Зураг-1.3



Зураг-1.4

1.1.3 Улаанбаатар хотын зүүн бүсийн “Амгалан” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажил:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/524 захирамжийг үндэслэн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт, хөгжлийн газартай байгуулсан №НХААГ 21/175/2 дугаартай гэрээ, №2021/05 дугаартай зургийн даалгаврын дагуу “Амгалан” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын одоогийн байдлын судалгаа, орон зай, нийтийн тээвэр, ачаа тээвэр, гамшигийн менежмент, хог хаягдлын менежмент, ногоон байгууламж зэрэг төлөвлөлтийн шийдлийг боловсруулсан. Танилцуулгыг бэлдэж, иргэд олон нийтийн хэлэлцүүлгээр оруулан санал хүсэлтийг тусган эцсийн тайланг Барилга хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Шаардлагатай нэмэлт материалуудыг боловсруулан Улсын магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсгээр хянуулж, магадлалын нэгдсэн дүгнэлт гарч захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн.



Зураг-1.5

1.1.4 Шинэ зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил:

2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2022/23 дугаартай гэрээ, 2021/84 дугаартай зургийн даалгаврын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх “Шинэ зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /Төв аймаг, Сэргэлэн сум/ боловсруулах ажлын эцсийн тайланг хийж дуусган хүлээлгэн өгсөн. Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.




Зураг-1.6

1.1.5 Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулах ажил:

2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2021/493 дугаартай гэрээ, 2021/69 дугаартай зургийн даалгаврын дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Монголын Архитекторуудын эвлэлийн Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн. Эцсийн тайланг боловсруулж дуусган Барилгын хөгжлийн төвд магадлал хийлгэсэн.

2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн бөгөөд 08 дугаар сарын 09-ний өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоол батлуулсан.



Зураг -1.7

1.1.6 Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” ажил:

2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Барилга хот байгуулалтын Яамтай байгуулсан 2022/226 дугаартай гэрээ, зургийн даалгаврын дагуу “Орхоны хөндийд шинэ суурьшлын бүс”-ийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Монголын Архитекторуудын эвлэлийн Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Барилга хот, байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал зөвлөмжийг авсан. 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр улсын магадлалын нэгдсэн дүн гарсан. 2023 оны 08-р сарын 18-ны өдөр Барилгын хөгжлийн төвийн Зураг төслийн хяналтын хэлтэст хүлээлгэн өгсөн.



Зураг-1.8

Тус ажлын хүрээнд Зам тээврийн хөгжлийн яам дээр байгуулагдсан ажлын хэсэгт Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн сонгосон байршлууд болох Өвөрхангай аймгийн Хархорин сумын Онгоцон хөндий, нисэх буудал, Архангай аймгийн Өгийнуур сум, Тоглохын талд газар дээр нь очин танилцуулах, газарзүйн нөхцөл хэв шинж байдлын тандалт судалгаа хийх замаар авто зам, зам тээвэр, төмөр зам, агаарын тээвэр зэрэг төлөвлөлтийн хувилбаруудыг дэвшүүлэхэд судалгааны материалаар хангах, газрын гадаргын хэв шинж, газрын налуужилт, тэгш байдлыг үзэж судлах, газар дээрх объектын судалгаа, зураглал, тэмдэглэгээг хийх, ажлын хэсгийн бүрэлдхүүнийг нэгдмэл мэдээллээр хангаж ажиллалаа.

1.1.7 Эмээлт эко аж үйлдвэрийн парк-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажил:

“Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/779 дугаартай захирамжийн дагуу Эхлэлийн тайланг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монголын Архитекторуудын эвлэлийн Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгсөн. Дундын тайланг 2022 оны 11 дүгээр сарын 09 нд Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүлээлгэн өгсөн. 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр захиалагч байгууллага болох “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” НӨААТҮГ-ын захиргаанд, 3 дугаар сарын 15-ны өдөр Дэлхийн банкны мэргэжилтнүүдэд төлөвлөлтийн шийдлээ тус тус танилцуулсан.

2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XIII хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн. Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.



Зураг-1.9

Хүснэгт 1.1- Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт

№	Төсөл арга хэмжээ	Хэрэгжилт	Үнэлгээний шалтгаан тайлбар
1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулна.	<p>2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан ХБХГ/ХТСИ-А/860-1 дугаартай гэрээний дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан дуусгаж 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан.</p> <p>Засгийн газарт өргөн барих тогтоолын төсөл хавсралт материалуудыг бэлтгэн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тогтоолын төсөлд яамдуудаас санал авах ажлыг Хот байгуулалт, хөгжлийн газар, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран гүйцэтгэсэн. 2022 оны 06 дугаар сараас 10 дугаар сарын хооронд яамдуудын санал зөвлөмжийг тусган ажилласан ба шинээр томилогдсон сайд нараас санал авсан. Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамдуудаас өргөн мэдүүлэх зөвшөөрөл авах хугацаанд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд “Шинэ тойрог зам”, “Сэлбэ сэргэлт”, “Тусгай замын их багтаамжийн автобус төсөл /BRT/ төслүүдийг харилцан уялдуулж нэмэлтээр тусгуулах ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хамтарсан 94/А/443 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар батлагдсан.</p> <p>Захирамжийн дагуу БХБЯамны Дэд Сайдад төлөвлөгөөний төслийг танилцуулж, ажлын хэсгийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд тусгасны дагуу одоогийн байдлын суурь мэдээллийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган ажиллаж байна. 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс холбогдох яамдуудад танилцуулж зөвшилцөөд байна.</p>	<p>85% /нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд/</p> <p>Одоогийн байдлын суурь мэдээллийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган ажиллаж байна.</p>
2	Улаанбаатар хотын 2040 он		60%

	хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулна.	2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2021/175 дугаартай гэрээний дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд 2040 оны ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.	Ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй
3	Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулна.	2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн БХБЯ-тай байгуулсан 296 тоот гэрээний дагуу Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг боловсруулж хүлээлгэн өгсөн ба 2020-2021 онд НИТХ-аар 3 удаа хэлэлцүүлсэн бөгөөд 2020 оны 06 дугаар сарын хурлаар 2040 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах шийдвэр гарч хойшлуусан бөгөөд 2040 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа НИТХ-аар батлуулахаар хүлээгдэж байна.	Ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй
4	Хот төлөвлөлтийн норм, дүрэмд заасан хүн ам, барилгажилтын нягтрал хэтэрсэн хэсгийн судалгааг боловсруулж, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлнэ.	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдаж, эрх бүхий байгууллагын шийдвэр гарч, зургийн даалгавар батлагдсаны дараа гүйцэтгэнэ.	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдаж, эрх бүхий байгууллагын шийдвэр гарч, зургийн даалгавар батлагдсаны дараа гүйцэтгэнэ.

1.2 ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган тайлагнах ажлын хүрээнд:

- Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын хэсгийн шалгалтын үед өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж холбогдох ажилтнуудад хүргэн хэрэгжилтийг ханган зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын

тайланг хагас жил, жилийн эцсээр тайлагнан ажиллаж байна. Эхний хагас жилийн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 01/267 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

- Нийслэлийн байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн систем дэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ дэд системд 2023 оны 04 дүгээр сарын 25, 2023 оны 06 дугаар сарын 05, 2023 оны 06 дугаар сарын 28, 2023 оны 08 дугаар сарын 30-нд бодлогын баримт бичиг, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, бусад үзүүлэлтийн тайланг тус тус хугацаанд нь оруулж биелэлтийг тооцуулсан.

- 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоолын дагуу "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 4 зорилго, 43 зорилттойгоор батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоолын хүрээнд 2023 онд "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу байгууллагын зардал хэмнэх сар бүрийн хуваарийг гарган биелэлтийг тооцон ажиллаж байна.

Хүснэгт 1.2 Тайлан биелэлт хүргүүлсэн тухай

АНГИЛАЛ	2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛ	2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ	2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛ	2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС
Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт	2023.04.25 UB ERP программаар	2023.06.23 01/263 тоот албан бичгээр	2023.08.30 UB ERP программаар	2023.12.28 UB ERP программаар
Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	2023.04.14 01/118 тоот албан бичгээр	2023.06.26 01/270 тоот албан бичгээр	-	2023.12.11 01/543 тоот албан бичгээр
Нийслэлийн Засаг даргатай байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ний биелэлт	2023.06.26 01/118 тоот албан бичгээр	2023.06.26 01/270 тоот албан бичгээр	-	2023.12.11 01/543 тоот албан бичгээр
Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Хагас жил, жилийн эцсээр гарах тайлан	2023.06.16 01/253 тоот албан бичгээр	-	

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүргийн биелэлтийн мэдээ	7 шуурхайн 22 үүргийн биелэлтийг гаргаж backend.ulaanbaatar.mn нэгдсэн системд байршуулав.	14 шуурхайн 53 үүргийн биелэлтийг гаргаж backend.ulaanbaatar.mn нэгдсэн системд байршуулав.	21 шуурхайн 72 үүргийн биелэлтийг гаргаж backend.ulaanbaatar.mn нэгдсэн системд байршуулав.	25 шуурхайн 77 үүргийн биелэлтийг гаргаж backend.ulaanbaatar.mn болон UB ERP программын Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системд байршуулав.
Байгууллагын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан		2023.07.05 01/290 тоот албан бичгээр		2024.01.04
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 онд хөгжүүлэх хөтөлбөрийн биелэлт	-	2023.07.05 01/289 тоот албан бичгээр	2023.10.19 01/436 тоот албан бичгээр	
Нийслэлийг 2021-2024 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	-	2023.07.05 01/287 тоот албан бичгээр		

1.3 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, АЛБАН ДААЛГАВАР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1592 дугаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны ажил дүгнэх тухай” захирамжийн дагуу байгууллагын даргын А/17 дугаар тушаалаар зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөөг баталж биелэлтийг хагас жил, жилийн эцсээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/312 дугаар “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай захирамжаар байгууллагын даргын тушаалаар 8 хэлтэс 81 хүний орон тоотойгоор баталсан.
- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/492 дугаартай захирамжаар “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” ажлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/688 дугаартай “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах тухай” захирамжаар ирүүлсэний дагуу 2023 оны орлого, зардлын сар, улирлын хуваарийг гарган, үйл ажиллагааны менежментийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хамтарсан 94/А/443 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу БХБЯамны Дэд Сайдад төлөвлөгөөний төслийг танилцуулж, ажлын хэсгийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд тусгасны дагуу одоогийн байдлын суурь мэдээллийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган ажиллаж байна.
- 2023 оны 08 сарын 08-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/893 дугаартай “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр эхэлсэн бөгөөд дундын тайланг боловсруулан ажиллаж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу нийслэлийн байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн систем дэх Өргөдөл, гомдлын дэд системд өргөдөл, хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/1106 дугаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж байна.

1.4 НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ, ҮР ДҮН

1.4.1 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн

Нийслэлийн удирдах ажилтнуудын 28 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагад харьяалагдсан 72 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж backend.ulaanbaatar.mn сайтад, 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс хойш үүрэг даалгаврын биелэлтийг

UB ERP нэгдсэн систем дэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ дэд системд оруулан ажиллаж байна.


- Монгол улсын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний дагуу байгууллагын зардал хэмнэх сарын хуваарийг гаргаж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Биелэлтийг сар бүр гаргаж, хэмнэсэн зардлын тайланг Нийслэлийн Өмчийн харилцааны газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлагнан ажиллаж байна. “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн хүрээнд байгууллагын зардалд хяналт тавин батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон бусад бүх төрлийн зардлыг хэмнэж, хэмнэлтийн горимд шилжин ажиллаж бараа материалын үлдэгдэл нөөцийг боломжит хэмжээнд бууруулан ажиллаж байна.
- “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгах санал, 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг 05 дугаар сарын 31-ний өдөр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.
- Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолуудын хэрэгжилтийг ханган хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, журам, батлагдсан контракт гэрээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүрээнд ил тод, шуурхай зохион байгуулан, ажлын уялдаа холбоог сайжруулан, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг улирал тутамд тавих хяналтыг эрчимжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад чиглэсэн дараах аянуудыг зарлан ажиллаж байна. Үүнд:

1. Байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/11 дүгээр “Ажил эрчимжүүлэх тухай” тушаалаар /Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлд “Шинэ тойрог зам”, “Сэлбэ сэргэлт”, “Тусгай замын их багтаамжийн автобус төсөл BRT”, “Сонсголт” болон бусад шаардлагатай төслүүдийг харилцан уялдуулж боловсруулахтай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хооронд ажил эрчимжүүлэн ажилласан.
2. Байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/12, А/14 дүгээр “Ажил эрчимжүүлэх тухай” тушаалаар Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, замын хөдөлгөөний нягтралыг бууруулах авто замын сүлжээг бий болгох “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг ажил эрчимжүүлэх хугацаанд зохион байгуулан 2023 оны 05 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 07-ны хооронд ердийн ажлын цагийн хуваарийг уртасгаж /09:00-21:00/, бямба гаригт /11:00-20:00/ байхаар зохион байгуулж тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

1.4.2 “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 134 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 70 дугаар захирамж, Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн сайдын А/23 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/492 дугаар захирамжаар “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” ажлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж дууссан.



Зураг-1.10

Зургийн даалгавар батлуулах ажлын хүрээнд:

Барилга, хот байгуулалтын яамны сайд, Нийслэлийн засаг дарга нарын хамтарсан №2023/09 дугаартай зургийн даалгавар 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан. Үндсэн зургийн даалгаврын дагуу туслан гүйцэтгэгч нарын зургийн даалгаврыг боловсруулж Хот төлөвлөлт, судалгааны институт батлаад байна.

Үүнд:

- Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник, эдийн засгийн үндэслэл, усны барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн зөөх, шилжүүлэх шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгавар;
- Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх инженер-геологийн судалгааны ажил боловсруулах даалгавар;
- Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх байгаль орчны төлөв байдлын болон нарийвчилсан үнэлгээний даалгавар;

- Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх гүүр, гүүрэн байгууламж, зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар;
- Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх геодези, байр зүйн зураглалын даалгавар;

Автозамын трасс батлуулах ажлын хүрээнд:

Сэлбэ сэргэлт төслийн автозамын трассыг нийт 21 байгууллагатай зөвшилцөн батлуулж Барилга хот байгуулалтын яам, Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн замын хөгжлийн газарт актаар хүлээлгэн өгсөн.

Загвар зураг батлуулах ажлын хүрээнд:

Сэлбэ сэргэлт төслийн тохижилт, зам гүүрийн загвар зураг /эскиз/-ийг Хот байгуулалт хөгжлийн газрын 39-р мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж Нийслэлийн ерөнхий архитектороор батлуулаад байна.

ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд:

Төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 98 хувьтай гүйцэтгэж байна. Трассын дагуу 2 тийш 350 метрийн радиуст хамрагдаж буй 4 дүүргийн 24 хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсруулж дууссан.

ТЭЗҮ-г Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурал, Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурал, Барилга хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Усын нөөцийн зөвлөлийн хурал, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлж Улсын экспертиз хийлгэх ажил хийгдэж байна.

Далан, авто зам, гүүрний тохижилтын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аас эксперт томилон

- Зам гүүрийн нарийвчилсан зураг төсөлд улсын магадлал хийгдсэн
- Зам гүүрийн барилга угсралтын төсөвт улсын магадлал хийгдсэн

“Барилга хөгжлийн төв” ТӨҮГ-аас эксперт томилон

- Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төсөлд улсын магадлал хийгдсэн
- Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн барилга угсралтын Багц 1, Багц 2 төсөвт улсын магадлал хийгдсэн.
- Тохижилтын ажлын зурагт улсын магадлал хийгдсэн
- Тохижилтын ажлын төсөвт улсын магадлал хийгдсэн

Төслийн хүрээнд зургийн даалгаварт тусгагдаагүй техник эдийн засгийн үндэслэл хот байгуулалтын баримт бичигт Барилгын хөгжлийн төвөөр магадлалд хянуулах, Багц – 3 үерийн байгууламжийн ажлын зураг төсвийг Барилга хөгжлийн төвийн дэргэдэх төсвийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар, техник эдийн засгийн үндэслэлийг Зам, тээвэр хөгжлийн яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх гэсэн 3 үүрэг даалгаварын дагуу гүйцэтгэж байна.



Зураг- 1.11



Зураг-1.12

1.4.3 “Төв зам дагуух 1-р эгнээний барилга байгууламжид тавигдах стандарт”-ын судалгаа

Хойд талаас 32-н тойргоос урагшаа Хан-Уул дүүргийн Мишээл төв хүртэл, Баруун талдаа Сонгинохайрхан дүүргийн Саппорогийн уулзвараас Зүүн талдаа Баянзүрх дүүргийн “Монгол ард эскадрилийн хөшөө” хүртэл бүсэд нүүрний нэгдүгээр эгнээнд хаягдал төмөр, машин угаалга, дугуй, авто машин засвар, вьетнам засваруудын үйл ажиллагаа эрхлэхгүй байх, худалдаа, үйлчилгээний стандартыг шинэчлэх зэрэг ажлуудын талаар санал, боловсруулж танилцуулга бэлтгэж боловсруулав.



Зураг-1.13

1.4.4 “1000 автомашины зогсоол”-ын судалгаа

Хан-Уул, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн автозамын шалгах бүртгэх товчоодод 1000 машины зогсоолыг байгуулах төсөв, тооцоо судалгааг хийх ажлын үндэслэл, газар дээрх одоогийн байдлын судалгаа, SWOT дүн шинжилгээ, олон улсын туршлага болон автомашины зогсоолын стандартын талаар судалж судалгааны дэлгэрэнгүй танилцуулга болон хураангуй танилцуулгыг хийж боловсруулав.



Зураг-1.14



Зураг-1.17

1.4.8 2023 оны “Улаанбаатар мөнгөн шөнө” шинэ жилийн арга хэмжээний төлөвлөгөөний схем зураг боловсруулах ажил



Зураг-1.18

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

• Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хариуцлагын гэрээ байгуулан, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг Нийслэлийн

Засаг даргын Тамгын газарт 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 01/270 тоот албан бичгээр хүргүүлсэн.

• 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 116 дугаар “Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн” тогтоолоор “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийг баталсан. Дүрмээр хот байгуулалтын суурь судалгаа, хот төлөвлөлт зураг төслийн баримт бичиг боловсруулах болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторинг хийх үндсэн чиг үүрэгтэйгээр баталсан. Чиг үүргийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
2. Улаанбаатар хотын “Шинэ төв” дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажил
3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 134 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 70 дугаар захирамж, Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн сайдын А/23 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/492 дугаар захирамжаар “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах”
4. “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлууд хийгдэж байна.
5. Улаанбаатар хотын зүүн бүсийн “Амгалан” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажил
6. Шинэ зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил
7. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулах ажил
8. Эмээлт эко аж үйлдвэрийн парк-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажил
9. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлууд хийгдэж дууссан.
10. Судалгааны хэлтсүүдийн төлөвлөгөөнд туссан хот төлөвлөлтийн салбартай холбогдох судалгааны ажлууд
11. Зохиогчийн хяналтын ажлууд
12. Ерөнхий төлөвлөгөөний хяналт, мониторинг

2.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ГАРСАН ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮД, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

2.2.1 "Хүний нөөцийн хөгжил", "нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан

2023 оны Хүний нөөцийн хөгжил, Нийгмийн баталгааг хангах 5 бүлэг 53 арга хэмжээ бүхий хөтөлбөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагад үр бүтээлтэй ажилласан ажилтнуудад зуслангийн газар олгох ажил хийгдэж байна. Хөдөлмөрийн дотоод журмын 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасны дагуу Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэр, Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн даргын тушаалаар 17,650,000 төгрөгийг буцалтгүй тусламж, тэтгэмжээр олгосон.

Хүснэгт 2.1 Төлөвлөгөөний биелэлт

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	20	17	2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 8 сургалт, төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 сургалтыг дотоодод зохион байгуулан ажилласан.Үүнд: <ul style="list-style-type: none"> ISO 9001-г байгууллагад нэвтрүүлэх бэлтгэл ажлын сургалт “Чанарын менежментийн тогтолцоо- Дотоод аудит” Мэдээлэл технологийн шинэ ололт амжилтыг байгууллагад нэвтрүүлэх ажлын хүрээнд Monday программын сургалт Цахилгаан соронзон долгион сургалт Гадаад сургалтын хүрээнд: <ul style="list-style-type: none"> 01 дүгээр сарын 20-ны өдөр ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам, Дээд боловсролын Холбооны улсын автономит боловсролын байгууллага, М.К.Аммосовын нэрэмжит зүүн хойд холбооны их сургуулийн харъяа Якутск хотын Инженер, Техникийн институттэй хамтарсан цахим уулзалт хийсэн. Сургалтаар “Хүйтэн цаг ууртай хотуудын хот төлөвлөлт” сэдвээр гүйцэтгэсэн төслүүдээ танилцуулж хот төлөвлөлтийн чиглэлийн сургалтад Институтийн ажилтнуудыг хамруулах, зохион байгуулах ажилд хамтарч ажиллах саналыг тавьж өөрсдийн сургалтын чиглэл болон хөтөлбөрийг илгээсэн.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	14	8	
			Мэргэшүүлэх сургалт	9	3	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	-	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	40	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	25	
			Эрэгтэй албан хаагч	-	15	
			Удирдах албан тушаалтан	-	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	38	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:	100%	100%			

			<p>Нийт албан хаагчдад эзлэх хувь</p>	<ul style="list-style-type: none"> • Мэргэшүүлэх сургалтын хүрээнд зураг төслийн REVIT программын сургалтад 20 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд 2023 оны 08 дугаар сард сертификатаа гардаж авна. Тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын хүрээнд Архивын эрхлэгч Ж.Халиунаа, бичиг хэрэг даргын туслах М.Соёл-Эрдэнэ нарыг архив албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамруулсан. <p>Төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 сургалтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг “Монгол ардын тоглоом наадам” “Гэр бүлийн харилцаа” “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” зэрэг сэдвүүдээр мэргэжлийн сургагч багш нартай хамтран зохион байгууллаа. “Монгол ардын тоглоом наадам” сэдвээр Олон Улсын оюун ухааны музейн дэргэдэх Оюуны оньс дунд сургуулийн багш Э.Энхтөр, “Гэр бүлийн харилцаа” сэдвээр Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Энхжаргал, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр Хан-Уул дүүргийн Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн Гэр бүлийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн Б.Бямбацэцэг нар тус тус илтгэл хэлэлцүүллээ. Сургалтын дараах сэтгэл ханамжийн судалгааг QR код уншуулан https://www.mentimeter.com/login вэбээр 6 асуултын хүрээнд 1-10 оноогоор үнэлгээ өгүүлэхэд дундаж оноо 8,9 гарсан нь сургалтын дараах сэтгэл ханамж өндөр үнэлэгдсэн байна. • MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага, баримтлах стандартуудын талаар Хяналт, судалгаа мониторингийн хэлтэстэй хамтран 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр дотоод сургалт зохион байгуулж сургалтын дараах сэтгэлт ханамжийн судалгааг www.mentimeter.com сайтаар авахад судалгаанд нийт 23 албан хаагч оролцож 7,9 оноо өгсөн байна. Мөн сургалтын дараа сургалтын агуулгын хүрээнд https://kahoot.com вэбээр
--	--	--	---------------------------------------	--

						асуулт хариултын тэмцээн зохион байгуулахад Эдийн засаг судалгааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Баярмаа 3848 оноогоор нэгдүгээр байр, 3677 оноогоор Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Анхбаяр, 3189 оноогоор Хот төлөвлөлтийн хэлтсийн Архитектор С.Ууганбаяр нар шалгарч гарын бэлгээр шагнагдлаа.
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1	Гадаад сургалтад хамруулсан байдал:			<p>1. 01 дүгээр сарын 20-ны өдөр ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам Дээд боловсролын Холбооны улсын автономит боловсролын байгууллага, М.К.Аммосовын нэрэмжит зүүн хойд холбооны их сургуулийн харъяа Якутск хотын Инженер, Техникийн институттэй цахим уулзалт хийсэн бөгөөд тус институтийн зүгээс “Хүйтэн цаг ууртай хотуудын хот төлөвлөлт” сэдвээр гүйцэтгэсэн төслүүдээ танилцуулж ХТСИ-тэй хот төлөвлөлтийн чиглэлийн сургалтанд ХТСИ-ийн ажилтнуудад хамруулах, зохион байгууллах ажилд хамтарч ажиллах саналыг тавьж өөрсдийн сургалтын чиглэл болон хөтөлбөрийг илгээсэн. Тус саналтай танилцан 02 дугаар сарын 14-ний өдөр талууд цахим хурал хийж үнийн саналыг ОХУ-ны талаас танилцуулсан бөгөөд сургалтын санал одоогоор эцэслэгдэх шатандаа явж байна</p> <p>2. Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилттэй URGENT төслийн хүрээнд ХСМХ-ийн дарга Г.Уранбайгал, Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Хуланзаяа нар Итали улс руу томилолтоор ажилласан.</p>
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	100%	98%	REVIT программын сургалтад 8,800,000 төгрөгийг зарцуулсан. Худалдан авах ажиллагааны А/3 сертификат олгох сургалтад зориулж 255,000 мянган төгрөг зарцуулсан, Сургалтын төлөвлөгөөнд нийт 62,000,000 төгрөгийг сургалтад зарцуулахаар төлөвлөсөн.

	зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	14,2%	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/312 дугаар “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай захирамжаар байгууллагын даргын тушаалаар 8 хэлтэс 81 хүний орон тоотойгоор батлагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 52 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. шилжилт хөдөлгөөнөөр ажлаас гарсан 15 ажилтан, шинээр ажилд томилогдсон 10 ажилтан байна.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	100%	38%	-Залуучуудын холбооны шагналд -975,000 -Оны шилдэг ажилтан шагналд- 10,137,600 -Оны шилдэг хэлтэст 18 сая төгрөг зарцуулсан байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	100%	100%	2010 оноос хойш шинэчлэгдээгүй байсан хоол унааны мөнгө УЗ-ийн 2023 оны 09 сарын 08-ний өдрийн 02 тоот тогтоолоор өдрийн хоолны мөнгө -19200 төгрөг, унааны мөнгө 800 төгрөг нийт 20000 мянган төгрөг олгож байна.
5.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	5.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	100%	100%	2023 оны бизнес төлөвлөгөөнд тусган батлагдсаны дагуу 17,650,000 төгрөгийг 5 албан хаагчид буцалтгүй тэтгэмжээр олгосон бол Нийт 53,511,330 төгрөгийг албан хаагчдын нийгмийн баталгааг хангах бусад арга хэмжээнд зарцуулжээ. Үүнд: 1. Даргын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Б/21 дугаар тушаалаар Эдийн засаг, судалгааны хэлсийн мэргэжилтэн Б.Цэрэнтогтох эрүүл мэндийн шалтгаанаар хэвтэн эмчлүүлж байсан тул 500,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. 2. Даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар Хот төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхтуулын төрсөн аав нас барсан тул байгууллагын дотоод журмын дагуу 1,100,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. 3. Даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Б/64 дугаар тушаалаар Хот төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ш.Баяржавхлангийн ээж хүнд өвчний улмаас БНХАУ-д эмчлүүлэх болсон тул өөрийн гаргасан хүсэлтийг нь үндэслэн 7,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

					<p>4. Даргын 2023 оын 05 дугаар сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын нийт ажилтны 70 хүүхдүүдэд дархлаа дэмжих бүтээгдэхүүн авах зардалд 3,500,000 төгрөг, Хүүхдийн паркийн тоглоомын эрх 1,400,000 мянган төгрөг зарцуулжээ.</p> <p>5. Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Б/76 дугаар тоот тушаалаар Захиргаа, менежментийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбатад эрүүл мэндийн шалтгааны улмаас 2,333,960</p> <p>6. Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн даргын Б/95 дугаар тоот тушаалаар Захиргаа, менежментийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбатад эрүүл мэндийн шалтгааны улмаас 5,666,040 төгрөг зарцуулсан байна.</p> <p>7. Шинээр хүүхэдтэй болсон Ахлах мэргэжилтэн Н.Мөнхзүлд Б/126 тоот тушаалаар 550,000 төгрөг</p> <p>8. Хүүхэд асрах чөлөөтэй албан хаагч Д.Солонгын шинээр мэндэлсэн хүүхдэд 550,000 төгрөгийн тэтгэмж олгосон байна.</p> <p>9. Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн мэргэжилтэн, Монгол Улсын зөвлөх инженер Махранзын Эрдэнэцэцэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн дээд (Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон)-оор шагнагдсан тул хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 550,000 төгрөгийн тэтгэмж 255,550 төгрөгийн хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулав.</p> <p>10. Албан хаагчдын хүүхдүүдийг БИОМЕТРИЙН ЦОГЦ ТЕСТ арга хэмжээнд хамруулахаар 4 сая 800 мянган төгрөг</p> <p>11. Нийслэлийн засаг даргын спортын V Наадамд 5,313,120 төгрөг, спорт заал түрээслэх арга хэмжээнд 7,800,000 төгрөг</p> <p>12. Шинэ жилийн хүүхдийн бэлэг 4,600,000 мянга</p> <p>13. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 7,592,660 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p>
--	--	--	--	--	---

2.2.2 Хүснэгт -2.2 2023 оны сургалтын төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шаардагдах санхүүгийн нөөц	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах хэлтэс, албан тушаалтан	Хамтрах байгууллага, алба хаагч нар	Тайлбар	Үр дүн
Зорилго: Хот төлөвлөлт, судалгааны институтын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэхэд оршино.								
Нэг. Мэргэшүүлэх сургалт								
1	Мэргэшсэн зэрэг шинээр авах, сунгуулах багц цагийн сургалт	Дотоод нөөц	Мэргэшсэн зэрэг дээшилнэ	Жилдээ	ЗМХ, Хүний нөөцийн мэргэжилтэн	Монголын Архитекторуудын эвлэл, Барилгын хөгжлийн төв	О.Цолмон, Б.Лхагвасүрэн нар мэргэшсэн зэрэг шинээр авсан бол Н.Мөнхзул, Д.Хулан нар мэргэшсэн зэрэг сунгуулсан байна.	Нийт 8 албан хаагч төлөвлөгөөнд тусгагдсанаас 4 албан хаагч хамрагджээ.
2	Зөвлөх зэрэг авах	Дотоод нөөц	Зэрэг дээшилнэ	Жилдээ	ЗМХ, Хүний нөөцийн мэргэжилтэн	Монголын Архитекторуудын эвлэл, Барилгын хөгжлийн төв	Б.Батмөнх, С.Ууганбаяр зөвлөх зэрэг авахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан.	Биелээгүй
Хоёр.Мэргэжлийн программын сургалт								
3	REVIT программын сургалт	Дотоод нөөц			ЗМХ, Хүний нөөцийн мэргэжилтэн	Сургагч багш	Нийт 22 инженер, архитекторууд хамрагдаж байна.	Гэрчилгээгээ авахад бэлэн болсон бөгөөд 2024 оны 2-р улиралд багтааж авахаар төлөвлөгдөж байна.

Гурав. Богино хугацааны сургалт								
4	Гамшгаас хамгаалах сургалт	-	Нийт албан хаагч нар хамрагдаж, гамшгаас хамгаалах арга техник эзэмшинэ	Жилдээ		Улсын онцгой байдлын газар	2023 оны 04 дүгээр сарын 11-нд гамшгаас хамгаалах сургалт, 06 дугаар сарын 08-ны өдөр Гамшгаас хамгаалах дадлага сургуулилтад хамрагдсан	Биелсэн
5	Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын сургалт	Дотоод нөөц	Байгууллагын дотоод аудит бэлтгэх	Жилдээ		Стандарт хэмжил зүйн газар	Байгууллагын нийт албан хаагчид хамрагдсан.	Биелсэн
Дөрөв. Туршлага солилцох дотоод сургалт								
6	Ухаалаг хотын танилцуулга	Дотоод нөөц	Алба хаагч нарын төлөвлөгөө тайлан боловсруулах мэдлэг дээшилнэ.	Жилдээ	ЗМХ, Хүний нөөцийн мэргэжилтэн	Сургагч багш, И.Мягмарсүрэн	Дэд бүтцийн хэлтсийн Холбоо дохиоллын судалгаа төлөвлөлтийн мэргэжилтэн И.Мягмарсүрэн сургагч багштай хамтран зохион байгуулав.	Биелсэн
7	Monday цахим системийн сургалт	Дотоод нөөц	Системийг өдөр тутамдаа ашиглана.	1 дүгээр улиралд		ХСМХ, Б.Цэрэнтогтох	Monday цахим системийн танилцуулга, ашиглах зааврыг Б.Цэрэнтогтох танилцуулсан.	Биелсэн
8	Цахилгаан соронзон долгион	Дотоод нөөц		1 дүгээр улиралд		ДБХ, И.Мягмарсүрэн	Дэд бүтцийн хэлтсийн Холбоо дохиоллын судалгаа төлөвлөлтийн мэргэжилтэн	Биелсэн

							И.Мягмарсүрэн 2023.02.14-ны өдөр зохион байгуулсан.	
9	ISO 9001 ажлын хүрээнд байгууллагад дагаж мөрдөгдөх журмуудын танилцуулах сургалт	Дотоод нөөц		2 дугаар улиралд		ХСМХ, Д.Хулан	Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагад дагаж мөрдөгдөх журмуудын танилцуулах сургалтыг байгууллагын нийт албан хаагчдын дунд Хяналт,судалгаа мониторингийн хэлтэс зохион байгуулсан.	Биелсэн
10	“Зураг төсөл боловсруулах үндсэн үйл явцын схем”- ийг танилцуулах сургалт	Дотоод нөөц		2 дугаар улиралд		ХСМХ, Л.Ганбат	МУ-ын зөвлөх архитектор Л.Ганбат Зураг төсөл боловсруулах үндсэн үйл явцын схемийг нийт албан хаагчдад таницуулах сургалтыг заасан.	Биелсэн
11	Тайлан, төлөвлөгөө боловсруулах арга зүй	Дотоод нөөц	Тайлан төлөвлөгөө боловсруулах мэдлэг дээшилнэ.	3 дугаар улиралд		ЗМХ, Б.Тэнгэрцэцэг	ЗМХ-ийн Дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Б.Тэнгэрцэцэг 2023 оны 07 дугаар 31-ний өдөр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.	Биелээгүй

12	Албан хэрэг хөтлөлтийн сургалт	Дотоод нөөц	Албан хэрэг хөтлөлтийн мэдлэг дээшилнэ.	3 дугаар улиралд		ЗМХ, Ж.Халиунаа	ЗМХ-ийн Архивын эрхлэгч Ж.Халиунаа 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.	Биелээгүй
13	Архивын баримт бүрдүүлэлт	Дотоод нөөц	Архивын баримт бүрдүүлэх талаар мэдлэг дээшилнэ.	Жилдээ		ЗМХ, Ж.Халиунаа	ЗМХ-ийн Архивын эрхлэгч П.Оюунчимэг ХХНЖ-ын дагуу архивын баримт бүрдүүлэлтийн зөвлөмжийг хэлтэс бүрт зохион байгуулж ажилласан.	Биелсэн

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:

Тус институт нь: албан хаагчдыг мэргэжлийн болоод хувь хүний хөгжилд чиглэсэн цахим болон танхимын **17** удаагийн сургалтад **346** /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулснаас Гэрчилгээ сертификаттай **7** удаагийн сургалтад **33** албан хаагч хамрагдсан байна. Үүнээс REVIT программын сургалтад хамрагдсан 22 алан албан хаагч 2024 оны 2-р улиралд багтаан гэрчилгээгээ авна.

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дээд газраас болон байгууллагаас гадуурх дараах сургалтуудад албан хаагчдаа хамруулж ажиллаа.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт шинжилгээ, үнэлгээ арга зүй” сэдэвт сургалтад Дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Ш.Ариунгэрэл хамрагдаж Гэрчилгээ авсан.
- Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Төслийн удирдлагын үндэс” сургалтад Эдийн засаг судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Долгорсүрэнг хамруулан ажиллаа.
- НЗДТГ-ын хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Харилцан суралцах арга зүй” сургалтад хамрагдаж Сайн туршлагаа дэлгэрүүлэх арга хэмжээнд Архивын эрхлэгч Ж.Халиунтай хамтран “Байгууллагын архивыг цахим хэлбэрт шилжүүлсэн туршлага” сэдвээр танилцуулга бэлтгэн амжилттай хэлэлцүүлэн оролцлоо.
- НЗДТГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга сургалтад Санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Долгорсүрэн, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нар хамрагдсан бол ШУТИС УУСургууль дээр Геодезийн бакалаврын хөтөлбөрийн сургалт өдрийн ангид Ахлах мэргэжилтэн Д.Даваажаргал суралцаж байгаа тул суралцах нөхцөл боломжоор хангаж 7 хоногийн Пүрэв гариг бүрт цалинтай чөлөө олгож шийдвэрлэв.

2.2.3 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах ажлын хүрээнд:

Тус институт нь албан хаагчдын мэдлэг чадварыг харгалзан мерит зарчмын хүрээнд 2023 онд ахлах мэргэжилтнээр **1** албан хаагч, Хэлтсийн даргаар **2** албан хаагч дэвшүүлэн томилж, Хүүхэд асрах чөлөөтэй **1** албан хаагчийг үүрэгт ажилд эргүүлэн томилсон байна. Тайлант хугацаанд **10** албан хаагч шинээр томилогдож **15** албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хүний нөөцийн чиглэлээр: Б тоот тушаал тайлант хугацаанд 134 гарсан.

Нийт албан хаагчдын өмнө шагнагдсан болон шагнагдах боломжтой нэгдсэн судалгааг шинэчлэн хөтөлж Салбарын болон бусад шагналаар шагнахаар Нийт **37** албан хаагчийн материал бүрдүүлснээс

- Монголын Архитекторуудын эвлэлийн шилдэг архитектор шагналаар **2**
- Монголын залуучуудын холбооны шагналаар **15** албан хаагч
- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн хурлын хүндэт үнэмлэхээр **1** албан хаагч
- Нийслэлийн засаг даргын шагналаар **7**

- Барилга хот байгуулалтын яамны шагналаар **10** албан хаагч Нийт **35** албан хаагчийг шагнасан бол Нийслэлийн Хангарди одонгоор шагнуулахаар **2** албан хаагчийн материал илгээсэн нь хараахан хариу ирээгүй байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Институтийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны А/08 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөн. Тушаалын хавсралтыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100 хувь
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнтэй холбоо барих мэдээлэл, иргэдийг хүлээж авах цагийн хуваарийг байгууллагын http://pri.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	100 хувь
3.	Сар бүрийн эхэнд шилэн дансанд мэдээлэл оруулах	Тухай бүр хугацаанд нь хийж ажиллаж байна:	100 хувь
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Байгууллагад гарсан сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулсан, мөн Зангиа.мн-д байршуулан ажил гориллогчийн анкетыг бүрдүүлж удирдлагын түвшинд танилцуулан ажиллаж байна.	100 хувь
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг ISO 9001 чанарын стандартын хүрээнд шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.	100 хувь

3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	95 хувь
----	--	---	---------

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

- Хүний нөөцийн батлагдсан орон тоон дахь хөдөлгөөнийг сар бүр шилэн дансанд байршуулан хугацаа хэтэрсэн зөрчилгүй ажиллаж байна.
- Институтийн <http://upri.ub.gov.mn/> болон <https://www.zangia.mn/> олон нийтийн цахим хуудаст ажлын байрны сул орон тооны мэдээллийг байршуулж, холбогдох удирдах албан тушаалтнуудад **183** анкет илгээж, анхан шатны болон хоёр дах шатны шалгаруулалтыг ISO хүний нөөц сонгон шалгаруулалтын журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

2.3 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.3.1 Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 9 албан хаагчийн 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайлан мэдээг хугацаанд нь НЗДТГ руу хүргүүлсэн.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ажлын хүрээнд:		
1	Институтийн хэмжээнд 2023 оны ХАСХОМ гаргах 11 албан тушаалтан байсан бөгөөд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан “ХАСХОМ гаргах албан тушаал”-ын жагсаалтад хамрагдах албан тушаалтны судалгааг хүснэгтийн дагуу хугацаанд нь гаргаж НЗДТГ-ын Төрийн захиргааны Удирдлагын хэлтэст хүргүүлсэн болно.	100%
2	Тус институтэд ХАСХОМ гаргах 11 албан тушаалтны 2023 оны ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын мэдүүлгийг хугацаанд нь гаргуулж, бүртгэж тайлагнаж ажиллав. Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч буй мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2020 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг холбогдох дүрэм, журмын хүрээнд зохион байгуулан ХАСХОМ-1, ХАСХОМ-2 болон бусад тайлангуудыг	100%

	Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 91 дүгээр туушаалаар баталсан хавсралтуудын дагуу гарган НЗДТГ-ын Төрийн захиргааны Удирдлагын хэлтэст хүргүүлсэн болно.	
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан 1 мэдэгдэлийг www.meduuleg.iaac.mn сайтад байршуулав.	100%
4	Ерөнхий инженерээр 2023 оны 8 дугаар сард шинээр томилогдсон А.Баттөмөр, Хотын дизайнерийн хэлтсийн даргаар Б.Батмөнх нарын ХАСУМ болон холбогдох материалыг АТГ-т хүргүүлэн зөвшөөрөл авч тушаалыг гарган тухайн албан тушаал томилуулан Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулан ажиллав.	100%
5	АТГ-ын https://meduuleg.iaac.mn вэб сайтад ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн системд нэвтрэх нэр, нууц үг авч, Ерөнхий инженерээр томилогдсон А.Баттөмөр, Хотын дизайнерийн хэлтсийн даргаар шинээр ажилд томилогдсон Б.Батмөнх нарыг 30 хоногийн хугацаанд ХАСХОМ бөглүүлж, илгээн баталгааны хувийг хэвлүүлж, гарын үсгээр баталгаажуулав.	100%
6	АТГ-ын ЭБАТ-уудад зориулан зохион байгуулсан сургалтанд хамрагдав.	100%

“Авлигын эсрэг нэгдье” аянг дэмжиж, аяны талаарх мэдээллийн зурагт хуудсыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулж, олон нийтэд сурталчилсан.

Тайлант онд дээд шатны байгууллага болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан дараах хууль, эрх зүйн сэдэвт сургалтуудад холбогдох албан хаагчдыг цахимаар хамруулсан. Үүнд:

- ✓ Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “ХАСХОМ мэдүүлэх” сургалтад 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр, “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” сургалтад нийт албан хаагчид,
- ✓ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин” сургалтад 2 албан хаагч,
- ✓ Стандартчилал, хэмжил зүйн газраас зохион байгуулсан "Төрөөс стандартчилал, хэмжил зүйн талаар баримтлах бодлого", "Стандарт ба хөгжил" сургалтад 1 албан хаагч,
- ✓ Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, нийтлэг журам, стандартыг мөрдүүлэх, чадавхжуулах” сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.

2.3.2 Үндсэн үйл ажиллааны хүрээнд хийгдсэн гэрээ

Үндсэн чиг үүргийн хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар дараах гэрээг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллав.

Үндсэн гэрээний хүрээнд 2 гэрээг боловсруулан батлуулж дараах ажлууд хийгдэв.			
1	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гэрээ		30%
2	"Яармаг" хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг) ажлын гэрээ		50%
Туслан гүйцэтгүүлэх гэрээний хүрээнд 27 гэрээг боловсруулан батлуулж дараах ажлууд хийгдэв.			
1	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх Усны барилга байгууламжийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах гэрээ	“Престиж Инженеринг” ХХК	25%
2	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх геодези байрзүйн зураглалын ажил гүйцэтгэх гэрээ	Кад сүрвэй ХХК	80%
3	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх авто зам, гүүрийн инженерийн нарийвчилсан зураг төслийн ажлыг боловсруулах гүйцэтгэгчийн гэрээ	“Эм Си Пи Си Жи Ар” ХХК	25%
4	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх (Олимпын гүүр, Сонсголгонгийн гүүр хүртэлх) гүүрэн байгууламж болон авто зам, дугуйн зам, явган хүний замын талбайн инженер-геологийн судалгааны ажлын гүйцэтгэгчийн гэрээ	Инжгео ХХК	70%
5	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх Инженер геологийн судалгааны ажил, үйлчилгээг гүйцэтгэх гэрээ	“Сойл трейд” ХХК	50%
6	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх гүйцэтгэгчийн гэрээ	“Би Жи Эм Дистрибьюшн” ХХК	30%
7	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх авто зам, гүүрийн зураг төслийн	Арт Трасс ХХк	30%

	ажлыг боловсруулах ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ		
8	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах Цахилгаан хангамжийн хэсгийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлтөнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ялгуун баян ХХК	25%
9	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын Хууль, эрх зүйн орчны хүрээнд хийгдэх ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Мөнхцамхаг ХХК	50%
10	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд Өндөржилт, улаан шугамын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийн гэрээ	Д.Даваажаргал	25%
11	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын нийгэм эдийн засгийн хэсэгт зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	“Бесттринити” ХХК	20%
12	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд Авто замын зураг төсөл боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ч.Намшир	20%
13	“Орхоны хөндийд Шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд Олон Улсын тохижилтын ажлын судалгаа, тайлан боловсруулах гэрээ	“Ворлд Бридж” ХХК	100%
14	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх Усны барилга байгууламжийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах Дугаар: НЗДТГ 2023-А/492-ТГ-004 гэрээний өөрчлөлтийн гэрээ	“Престиж Инженеринг” ХХК	50%
15	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх Явган дугуйн замын ажлын зураг боловсруулах гэрээ	Н.Гансүх	50%
16	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн ажлын талбайд орсон холбооны худаг сувагчлал, кабелийн байгууламжийг шилжүүлэх, хамгаалах теникийн болон ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ	Д.Балмаа	50%
17	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн ажлын талбайд орсон ариутгах татуургын шугам сүлжээг	Ц.Цэрэндулам	50%

	зөөж шилжүүлэх, хамгаалах, техникийн болон ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ		
18	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн ажлын талбайд орсон ус хангамжийн шугам сүлжээг зөөж шилжүүлэх, хамгаалах, техникийн болон ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ	Г.Чимэд-Очир	50%
19	“Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн ажлын талбайд орсон цахилгаан байгууламжий шилжүүлэх, хамгаалах техникийн болон ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ	Б.Гэрэлчулуун	50%
Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын туслан гүйцэтгүүлэх 3 гэрээг шинээр байгуулав.			
1	“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”ний цахилгаан хангамжийн хэсэгт зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ж.Сарайдамба	50%
2	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /470440га/ боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн 2020.10.26-ны өдрийн ХТСИ/ЕТ/2040-НЭЗ/2020/02 тоот гэрээний нэмэлт гэрээ	"Бест тринити" ХХК	50%
3	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /470440га/-ний Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлыг боловсруулах түншлэлийн гэрээ	"Бест тринити" ХХК	50%
Үндсэн 2 гэрээг дүгнэж, нийт 4 туслан гүйцэтгэгч, зөвлөхийн ажил хүлээлцэх акт, гэрээ дүгнэх протокол үйлдэж, 2 туслан гүйцэтгэгч, зөвлөхийн дундын тайланг хүлээн авч, гэрээ дүгнэж, гэрээний бүрдүүлбэр хангах ажлуудыг гүйцэтгэв.			
Зохиогчийн хяналтын 5 гэрээг боловсруулан батлуулж гэрээний хүрээнд дараах ажлууд хийгдэв.			
1	“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын нийтийн тээврийн автобус паркийн цахилгаан хангамжийн ажлын явцад зохиогчийн хяналт хийх нэмэлт гэрээ		100%
2	Хөдөлгөөний удирдах төвийн барилга угсралтын ажлын явцад нэмэлт зохиогчийн хяналт хийх гэрээ		100%
Туслан гүйцэтгэгч			
1	“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын нийтийн тээврийн автобус паркийн цахилгаан хангамжийн ажлын явцад зохиогчийн хяналт хийх нэмэлт гэрээ		100%
2	“Шархад дэд төвийн ногоон орон сууцны төсөл-1”-ийн А, В, С, D блокийн барилга угсралтын явцад зохиогчийн хяналт хийх гэрээ		100%
3	Шатахуун түгээх станцын барилга барих ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээ		100%

2.4 ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

1.Тус Институтийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрийн хөрөнгөөр нийт 131,768.5 мянган төгрөгөөр компьютер, техник, тоног төхөөрөмж худалдан авахаар тусгагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 119,958.5 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, техник, тоног төхөөрөмж худалдаж авсан.

2.Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс тухайн сар бүрд зарласан тендерийн жагсаалтыг гарган хянуулж түүнээс 2023 оны жилийн эцсийн байдлаар 4 тендерт оролцохоор бүртгүүлсэн байна. Үүнээс:

- /нэг/ тендерт шаардагдах тусгай зөвшөөрлийн заалтыг хангаагүйн улмаас оролцоогүй
- /хоёр/ тендерийн хураангуйд шалгарсан боловч дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/287 захирамжаар хугацаа шахуу ажил орж ирсэнтэй холбоотойгоор тендерт оролцохоо хойшлуулсан.
- /дөрөв/ “Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, гадна тохижилтын ажлын зураг төсөл, төсөв” (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) хийх зөвлөх үйлчилгээний тендерийн хураангуйд орсон

2.5 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ, САНХҮҮГИЙН САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛАХ, ӨР АВЛАГЫГ БАРАГДУУЛАХ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮН

2.5.1 Институтийн санхүүгийн үйл ажиллагааг 2023 оны зорилтыг хангахад чиглүүлэн үр ашгийг дээшлүүлэх ажлын хүрээнд

1. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэл дэх төрийн аудитын газраас “Эвиденсе аудит” ХХК нь 2022 оны санхүүгийн тайланд аудитын хяналт, шалгалтыг хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг гаргасан болно.

2. Нийслэлийн Засаг даргын “Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг батлах тухай” А/688 дугаар захирамжаар батлагдсан 3,1 тэрбум төгрөгийн орлого болон 149,6 сая төгрөгийн ашгийн түвшинг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100 хувь биелүүлэн ажилласан.


3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Ашиг орлогын хуваарилалт тогтоох тухай” 2022 оны 114 тогтоолын дагуу санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 4,5 сая төгрөгийг орлогын албан татварт суутган ноогдол ашиг болох 40,9 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн болно.

4. Институтийн Удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар 2022 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг танилцуулж, 2023 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг батлуулах саналаа танилцуулан дэмжигдэн, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт зорилтот түвшинг хүргүүлж Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан болно.

5. Нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулах контракт гэрээний биелэлт болон бусад шаардагдах санхүүгийн тайлан, судалгаа, тоон мэдээллүүдийг тухай бүрт хүргүүлсэн. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэгдсэн судалгаа

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл
- Тээврийн хэрэгслийн 2022 оны жилийн мэдээний нэгтгэл
- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 2022 оны жилийн мэдээний нэгтгэл
- Биет бус хөрөнгийн бүртгэлийн 2022 оны жилийн мэдээний нэгтгэл
- Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 2022 оны жилийн мэдээг нэгтгэл
- НӨАУГ-тай байгуулсан 2022 оны контракт гэрээний балансын шинжилгээг 2023 оны 03 дугаар сарын 26-д албан тоотоор хүргүүлсэн.
- 2023 оны Нийслэлийн Засаг даргатай байгуулах контракт гэрээ байгуулахад шаардагдах санхүүгийн тайлан мэдээ



Зураг -2.3

6. Монгол улсын Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний дагуу зардал хэмнэх сар бүрийн хуваарийг гаргаж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Зардал хэмнэсэн тухай тайланг сар бүр гаргаж Нийслэлийн Өмчийн харилцааны газар болон Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлагнан ажиллаж байна.

Зардал хэмнэх үйл ажиллагааг зохион байгуулсанаар жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон бусад бүх төрлийн зардлыг хэмнэж, бараа материалын үлдэгдэл нөөцийг боломжит хэмжээнд бууруулж ажиллав.

2.6 ТАЙЛАНТ ОНЫ ТӨСӨВ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙ ШИНЭЭР САНААЧИЛЖ ХИЙСЭН БҮТЭЭЛЧ АЖИЛ, ЧАНАР ҮР ДҮН

- 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Барилга, хот байгуулалтын сайдын 245 дугаар тушаалын дагуу байгууллагын зураг төсөл, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тухай тусдаа 2 заалт

бүхий тусгай зөвшөөрөл болгон өөрчилсөн тул 2023 онд 21 заалт бүхий ЗТ19-449/23 дугаартай барилгын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийг Барилга, хот байгуулалтын яамнаас 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр шинэчлэн авсан. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заалт бүхий тусгай зөвшөөрлийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас авсан.



Зураг-2.4

- Байгууллагын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор бүтэц орон тооны өөрчлөлт хийж шинээр “Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтэс”-ийг үүсгэсэн. Одоогоор замын тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байна.

2.7 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2022 онд борлуулалтын орлогыг 3.04 тэрбум байх зорилт тавин ажилласан бол 2023 онд 3.17 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд борлуулалтын орлогын 48 хувийг Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн төсвийн болон бусад эх үүсвэрийн санхүүжилт, тендерийн сонгон шалгаруулалтаар 1.6 тэрбум төгрөгийн, он дамжин хийгдэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний орлогоос нийт 26 хувь буюу 893.4 сая төгрөг, 610.0 сая төгрөгийг судалгааны ажилтнуудын үйл ажиллагааны зардалд санхүүжих нийслэлийн төсвийн санхүүжилтээр бүрдэж байна.

Өөрийн хөрөнгийн санхүүжилтээр 2023 онд 24 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 131,7 сая төгрөгөөр авахаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлуулж түүний дагуу хөрөнгө оруулалтын ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан. Хэлтсүүд олон төрлийн өндөр хүчин чадалтай программ дээр ажилладаг учир хүчин чадал сайтай компьютер зайлшгүй хэрэгцээтэй байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31 ны өдрийн А/8 тоот захирамжаар 12 хүний орон тоотойгоор Зам тээвэр, судалгаа төлөвлөлтийн хэлтэс шинээр байгуулагдсантай холбоотойгоор шинээр өндөр хүчин чадалтай компьютер, тоног төхөөрөмжийг худалдаж авсан.

Хүснэгт 2.4- 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл/ мянган төгрөг

Данс	Огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Тавилга эд хогшил					4,018,090.90
Захиргаа менежментийн хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж					24,750,290.00
Хотын дизайны хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж					32,703,000.00
Зам тээвэр судалгааны хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж					21,305,000.00
Дэд бүтцийн хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж					6,655,000.00
Хот төлөвлөлтийн хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж					10,077,225.00
Архитектор төлөвлөлтийн хэлтэс					
Компьютер тоног төхөөрөмж	2023.08.07	ш	1.00	880,000.00	16,480,000.00
Хэвлэх, хувилах төхөөрөмж	2023.09.21	ш	1.00	1,989,900.00	1,989,900.00
Биет бус хөрөнгө	2023.08.07	ш	1.00	1,980,000.00	1,980,000.00
НИЙТ					119,958,505.90

Энэ онд худалдан авалтын төлөвлөгөөний гүйцэтгэл нь 91 хувьтай байна. Нийт худалдан авалтын 27 хувийг Хотын дизайны хэлтэс, Зам, тээвэр судалгааны хэлтэс 18%, 8 хувийг Архитектур төлөвлөлтийн хэлтэст компьютер тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

3.1 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ МӨРДӨЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн байгууллагын ХАБЭА-н 2023 оны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Хуулийн 28.1.6-д заасны дагуу ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж ажлын зургийн дагуу угсралтын талбайд зохиогчийн хяналт тавин ажиллах инженер техникийн ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүр хүргүүлэн 2023 оны гуравдугаар улирлыг байдлаар нийт 4 удаа заавар, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

- Хуулийн 28.1.8 дугаар зүйл заасны дагуу “Багатэнгэрийн голын эргийн тохижилт”-ын ажлын хүрээнд зохиогчийн хяналтаар ажиллах ажилтнуудад баригдаж буй барилга дээр хяналт тавих, аюулгүй ажиллагаа алдагдахаас сэргийлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлтэй харилцах талаар сургалтыг 2023 гуравдугаар улирлын байдлаар 2 удаа ажилтнуудад орсон.

- ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажилтай холбогдуулан гадуур ажиллах үеийн аюулгүйн зааварчилгааг байгууллагын нийт ажилтнуудад хүргүүлэв.

- Ажлын байрны эрүүл мэнд, эрүүл ахуйн хүрээнд хүн амын өвчлөлийг эрт илрүүлэх, хавдраас сэргийлэх зорилготой “Эрт илрүүлэг” хөтөлбөрт хамрагдаж буй ажилтнуудад цалинтай чөлөөг тогтмол олгож байна. 2023 оны 06 дугаар сарын байдлаар 17 ажилтан хамрагдсан байна.

- Байгууллагын даргын 2023 оны А/11, А/12, А/14 дүгээр “Ажил эрчимжүүлэх” тушаал гарсантай холбогдуулан ажилтнуудад ажлын байрны аюулгүйн зааварчилгааг хүргүүлж мөн ажилтнуудад ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

- Байгууллагын даргын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/36 тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар Дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Уянга томилогдон хавсрангаар ажиллаж байна.

ЗОХИОЛЧИН ХЯНАЛТ ХИРСЭН ТАГААРХ БҮЛЭГЭЙН МАНИ

№	ХАЙТГОС	АЖИЛТНЫ НЭВЭЛТ НӨӨ	ОН САР ӨДӨР	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ	ЭХЭГЦЭГЭЙН ХАНАЛТААР АЖИЛЛАХ АЖИЛ
1	АТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
2	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
3	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
4	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
5	АТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
6	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
7	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00
8	БЭТХ	Э.Уянга	2023.05.18	10:00

Бүртгэл хийгч: Э.Уянга

Зураг-3.1




Зураг-3.2

3.2 ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

3.2.1. Европын холбооны URGENT төсөлд оролцсон тухай

Гадаад харилцааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах ажлын хүрээнд” Хот төлөвлөлт, судалгааны институт нь 2021 оны 01 дүгээр сараас Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилттэй URGENT төслийн хамтрагч байгууллагын нэгээр ажиллаж байгаа бөгөөд энэхүү төсөл нь Монгол, Энэтхэг улсуудад мэдээлэл харилцаа холбооны технологийг сайжруулан, дээд боловсролоор дамжуулан уур амьсгалд ээлтэй, амьдрах боломжтой хотуудын ногоон ба цэнхэр дэд бүтэц, байгальд суурилсан шийдлүүдийг сурталчлах зорилготойгоор гадаад, дотоодын 13 байгууллагуудтай хамтран 2021.01.15 – 2024.01.14-ны хооронд хэрэгжих төсөл юм. Тус төслийн хүрээнд үе шатны тайлангуудыг цаг тухайд нь гаргаж бусад хамтрагч байгууллагуудтай өдөр тутамдаа мэйлээр болон утсаар харилцан шаардлагатай мэдээллүүдээр ханган ажиллаж байна.

Төслийн 4 дүгээр улирал 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр дууссан бөгөөд санхүүгийн болон техникийн тайланг боловсруулан 02 дугаар сарын 01-ний өдөр төслийн зохицуулагч Igor руу илгээсэн.



1. Staff Costs

Role Code (to encode in the final financial statement sheet)	Supporting Document Ref.	Name of Staff Member	Staff category	Activity N° (ex: WP2, Activity 2.3)	Short description of tasks and Results Achieved	From (dd/mm/yy)	To (dd/mm/yy)	Number of days (A)	Unit cost per day (in EUR) (B)	Total Calculated (in EUR) (A x B)	Check Data Encoding
Partner	S_FP_23	Uranbaikal Gungor	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.1	Revision of existing and development of new BSc/MSc course- Revised and provided feedback to existing and new course materials of all Mongolian partner universities.	15/10/22	23/01/23	2	33.00	66.00	
Partner	S_FP_24	Gerbat Luvsanrenchin	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.1	Revision of existing and development of new BSc/MSc course- Revised and provided feedback to existing and new course materials of all Mongolian partner universities.	15/10/22	23/01/23	3	33.00	99.00	
Partner	S_FP_25	Naranpatal Odov	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.1	Revision of existing and development of new BSc/MSc course- Revised and provided feedback to existing and new course materials of all Mongolian partner universities.	15/10/22	23/01/23	3	33.00	99.00	
Partner	S_FP_24	Gerbat Luvsanrenchin	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.2	Development of Ph.D. research framework - made revisions to Mongolian partner universities' course materials and research agendas, and provided suggestions and sent them to the universities.	15/10/22	23/01/23	4	33.00	132.00	
Partner	S_FP_23	Uranbaikal Gungor	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.3	On-site seminars for faculty and Ph.D. students, attended and presented "Pressing issues of the Blue Infrastructure" at "Urbanization and Environment-2022" meeting.	15/10/22	23/01/23	1	33.00	33.00	
Partner	S_FP_27	Saruul Punvoursun	Teacher/Trainer/Researcher	WP2, Activity 2.3	On-site seminars for faculty and PhD students, prepared and presented "Food risk management in Urban/semi city" at "Urbanization and Environment-2022" meeting.	15/10/22	23/01/23	1	33.00	33.00	

Зураг-3.3

Төслийн хүрээнд жил бүр уламжлал болгон төсөлд оролцогч байгууллагууд хамтран судалгааны семинар зохион байгуулдаг бөгөөд 2023 онд Монгол Улсын Их

“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

Сургуулиас зохион байгуулж буй эрдэм шинжилгээ, судалгааны цахим семинарт Хотын дизайны хэлтсийн архитектор С.Үүрцайх “Хотын ногоон байгууламж төлөвлөлт ба түүний нөлөө” илтгэл тавьж оролцсон.

05 дугаар сарын 24-ний өдөр Осака их сургуулийн профессор Takashi Machimura, URGENT болон ONE төслийн үндэсний зохицуулагч, МУИС-ийн профессор О.Алтансүх нар ХТСИ дээр ирж “УБ хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, байгаль орчны хэсгийн тандангийн суурь судалгаа зэрэгтэй тус тус танилцсан бөгөөд танилцуулгыг Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга Г.Уранбайгал хийсэн. Мөн байгууллагын удирдлагатай цаашдын хамтарч ажиллах боломжийн талаар хэлэлцсэн.



Зураг-3.4



Зураг-3.5

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2023 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Италийн Катаниа хотын Катаниагийн их сургуулийн “Архитектур, барилгын инженерийн сургууль” дээр зохион байгуулагдлаа. Уулзалтад Монгол, Энэтхэг, Герман Эстони зэрэг улсын төсөлд оролцогч 12 байгууллагын 29 төлөөлөгч оролцов. ХТСИ-ийг төлөөлж Хяналт, мониторингийн хэлтсийн дарга, байгууллага дахь төслийн менежер Г.Уранбайгал, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Хуланзаяа нар оролцсон.



Зураг-3.6


Уулзалтын үр дүн:

- Өмнөх улирлуудын төслийн үр дүнг дүгнэв.
- Их сургуулиудын онлайн платформ, сургалтын хөтөлбөртэй танилцаж хэрхэн сайжруулах талаар хэлэлцэв.
- Эцсийн тайлангуудыг бэлтгэх, хүлээлгэн өгөх хугацааг тодорхой болгов.
- Дараагийн уулзалт, семинаруудад хамтрагч байгууллагууд ямар үүрэгтэйгээр оролцохыг тодорхойлов.
- Цаашид хийгдэх ажлуудын талаар хэлэлцэж байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцов.



Зураг-3.7

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Оролцогч талуудын интерактив платформ дахь хамтарсан хамтын ажиллагаа”-ны хүрээнд 2023 оны 09 дүгээр 12-ны өдөр Монголын Геомэдээллийн холбоотой URGENT төслийн хүрээнд хамтран ажиллах урьдчилсан гэрээг байгуулсан. ХТСИ-ийг төлөөлж URGENT төслийн ХТСИ-ийн менежер Г.Уранбайгал, Геомэдээллийн холбооны тэргүүн Г.Өлзийсайхан нар тус тус гарын үсэг зурсан.



Зураг-3.8

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Монгол улсын Улаанбаатар хотод 2023 оны 10-р сарын 10-ны өдөр Төслийн хамтрагч байгууллага болох Хөдөө аж ахуйн их сургууль дээр “ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ИДЭВХЖҮҮЛЭЛТ” олон улсын зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдсан. Уг зөвлөлдөх уулзалтын зорилго нь хотын ногоон-цэнхэр байгууламж, байгальд суурилсан шийдэл, хот төлөвлөлт, амьдрахад таатай хотыг хөгжүүлэхэд олон улсын сургалт-судалгаа-төрийн-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн. Тус уулзалтад 5 улсын (Эстони, Герман, Монгол, Энэтхэг, Итали) 18 байгууллагын төлөөлөгчид оролцсоноос Монгол улсаас МУИС, ХАИС, МУИС-ийн Ховд салбар сургууль, ХТСИ, ҮЦХ, хувийн хэвшилээс идэвхитэй хамтран ажиллаж буй Мишээл байгаль орчин, танин мэдэхүйн хүрээлэн, Сурах чадварыг бэхжүүлэх төв, "Гарден сити" ХХК урилгаар оролцож, өнөөг хүртэлх хамтын ажиллагааны үр дүн, ач холбогдол болон цаашдын чиглэлээ танилцуулсан. ХТСИ-ийг төлөөлж Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга Г.Уранбайгал, хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Хулан, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Хуланзаяа нар тус тус оролцсон.



Зураг-3.9

3.2.2 Байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам Дээд боловсролын Холбооны улсын автономит боловсролын байгууллага, М.К.Аммосовын нэрэмжит зүүн хойд холбооны их сургуулийн харьяа Якутск хотын Инженер, Техникийн институттэй цахим уулзалт хийсэн бөгөөд тус институтийн зүгээс “Хүйтэн цаг ууртай хотуудын хот төлөвлөлт” сэдвээр гүйцэтгэсэн төслүүдээ танилцуулж ХТСИ-тэй хот төлөвлөлтийн чиглэлийн сургалтанд ХТСИ-ийн ажилтнуудад хамруулах, зохион байгуулах ажилд хамтарч ажиллах саналыг тавьж өөрсдийн сургалтын сургалтын чиглэл болон хөтөлбөрийг илгээсэн. Тус саналтай танилцан 02 дугаар сарын 14-ний өдөр талууд цахим хурал хийж үнийн саналыг ОХУ-ны талаас танилцуулсан бөгөөд сургалтын санал хэлэлцэн эцэслэж 9 дүгээр сард сургалтыг зохион байгуулахаар тохиролцсон.



Зураг-3.10

Доктор З.Д.Д. на основании полученных результатов обследования и результатов...
3.1. Анализ ситуации
 3.1.1. Анализ ситуации в сфере...
 3.1.2. Анализ ситуации в сфере...
 3.1.3. Анализ ситуации в сфере...

4.4. В целях повышения эффективности работы...
3. Анализ ситуации в сфере
 3.1. Анализ ситуации в сфере...
 3.2. Анализ ситуации в сфере...
 3.3. Анализ ситуации в сфере...

ФЕДЕРАЛЬНОЕ ГОСУДАРСТВЕННОЕ АУТОНОМНОЕ ОБРАЗОВАТЕЛЬНОЕ УЧРЕЖДЕНИЕ ВЫСШЕГО ОБРАЗОВАНИЯ «ФЕДЕРАЛЬНОЕ ГОСУДАРСТВЕННОЕ УНИВЕРСИТЕТ ИМЕНИ М.К. АММОСОВА»
СЧЕТ № 000-001649 от 03.10.2023
 Вид операции: Перевод средств с расчетного счета на расчетный счет...
 Сумма: 10 000,00 руб.
 Дата: 03.10.2023

Зураг-3.11

Эдийн засаг, судалгааны хэлтсийн Хог хаягдал, гамшиг, аюулгүй байдлын судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн О.Цолмон нь Ази, Номхон далайн сансрын шинжлэх ухаан, технологийн боловсролын төв (CSSTEAP)-ийн Энэтхэг улсын


“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

Ахмедаб хот дахь сансрын хэрэглээний төвд дэлхийн навигацийн хиймэл дагуулын системийг хот төлөвлөлттэй холбон судлах чиглэлээр 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 20-ны хооронд 9 сарын хугацаанд амжилттай суралцаад ирсэн. Энэ хугацаанд хиймэл дагуул, дэлхийн навигацийн системийг судлан гамшгийн менежмент, хог хаягдал болон байршлын одоогийн байдлын судалгааг хийж гүйцэтгэх чадварыг эзэмшин энэ сэдвийн хүрээнд диплом хамгаалаад ирсэн. Хог хаягдлын судалгааг survey ашиглан цуглуулж webтар дээр анализ бэлтгэх, онлайн форумд оруулах, цаг тухай бүрт нь шинэчлэн сайжруулах байдлаар цаашид ашиглах боломжтой.



Зураг -3.12

Энэтхэгт суралцах хугацаандаа мөн GIS болон BIM програмуудын хамтарсан 4 долоо хоногийн “MOOC” сургалтанд цахимаар сууж сургалтын гэрчилгээ авсан.




Зураг -3.13

Барилгын салбарын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Барилгын эрчим хүчний үр ашиг, Ногоон Барилгын Үнэлгээний Системүүд, Олон Улсын Санхүүгийн Корпорацын EDGE Ногоон Барилгын Үнэлгээний Системийн талаарх мэдлэгийг түгээж Ногоон барилгын үнэлгээний EDGE систем”-ийн дотоодын мэргэшсэн эксперт бэлтгэх зорилготой Ногоон барилгын програм хангамж, стандарт, үнэлгээний системийн мэргэжилтэн бэлтгэх сургалт 2023 оны 12 дугаар сарын 4-6-

“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ


ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба тус сургалтад ХТСИ-ийн мэргэжилтэн Б.Хуланзаяа, С.Үүрцайх нар амжилттай суралцаж IFC-ээс EDGE эксперт шалгалт өгөх эрхээ авсан.



Зураг -3.14

3.2.3 Олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах ажлын хүрээнд

Азийн Хөгжлийн Банкнаас зарласан Хөшгийн хөндийн ногоон, тэсвэртэй, шинэ дагуул хотын дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг бэлтгэх (ТА 56298-002 MON) тендерт Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь дотоодын зураг төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэйгээр Хонгконгийн NAREE компанитай хамтран материалаа илгээж эхний шатанд шалгарсан фирмүүдийн нэгээр шалгарсан. Дараагийн шат буюу техникийн санал боловсруулах үйл явцад шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэйгээр оролцсон. Энэ үе шатанд Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга Г.Уранбайгалын удирдсан ажлын хэсэг шаардлагатай цахим хурлыг зохион байгуулж илгээх мэдээллүүдийн боловсруулалт, танилцуулга зэргийг гүйцэтгэж хамтарч ажилласан.



Зураг-3.15

3.2.4 Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд

2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр “Солонгос Монголын Хөгжлийн Төв”-ийн захирал Ён Рэ Ким нь Улаанбаатар хотын гэр хорооллын талаар судалгааны ажлыг БНСУ-ын институт болон их сургуультай хамтран хийх ажлын хүрээнд ХТСИ-ийн хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудтай танилцаж ерөнхий мэдээлэл авахаар Хяналт,

“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

судалгаа мониторингийн хэлтсийн дарга Г.Уранбайгал болон хот төлөвлөлтийн зөвлөх архитектор Г.Нарангэрэл нартай уулзалт хийсэн.

Судалгааны ажлынхаа хүрээнд зохион байгуулах “Focus group seminar”-т зөвлөх архитектор Г.Нарангэрэлийг илтгэгчээр урьсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тус семинарт оролцож “Гэр хорооллын үүсэл, тархалт, хариу үйлдэл” сэдвийн дор илтгэл тавьж оролцсон.



Зураг-3.16

Тус уулзалтын үеэр тэрээр БНАСАУ-ын судалгааны төв болон Dongguk их сургуультай дээрх судалгааны ажлын хамтын ажиллагааны санамж бичгийн төсөлд хамтарч ажиллах саналыг ХТСИ-д тавьсан.

2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр БНСУ-ын “SPH компани”-ийн төлөөллүүд “УБ хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-тэй танилцахаар ХТСИ дээр уулзалт зохион байгуулж танилцуулгыг Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Тэлмэн хийсэн.



Зураг -3.17

“Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн рүү шилжих үеийн Улаанбаатар хотын хот төлөвлөлтийн харьцуулсан судалгаа” сэдэвт семинарыг БНСУ-ын Донгук их сургуультай хамтран 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Семинарт Хот төлөвлөлт, судалгааны институтын дарга, МУ-ын Зөвлөх архитектор Р.Амартүвшин болон байгууллагын удирдлагууд, Хяналт, мониторинг судалгааны хэлтэс, Солонгосын талаас ПАК Хи Жин (Судлаач


“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

Профессор, Донггук Их сургууль), ХАН Жае Хёон (Судлаач Профессор, Донггук Их сургууль), ХЁО Жеон Пил (Судлаач Профессор, Донггук Их сургууль), ЮУ Жи Сун (Эрдэм шинжилгээний ажилтан, Солонгосын Үндэсний нэгдлийн институт), СЭЗДС-ийн Ахисан түвшний профессор, Солонгос Монголын Хөгжлийн төвийн захирал Доктор КИМ Ён Рэ, орчуулагч СЭЗДС-ийн Ахлах багш Доктор Д.Отгонболд нар оролцож байгууллагын гадаад хамтын ажиллагаа, үйл ажиллагаанд эерэг үр дүн авчирсан.



Зураг-3.18

Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай холбоо тогтоож байнгын харилцаатай ажиллах ажлын хүрээнд БНСУ-ын Сөүл Институт, Хөх хотын Зураг Төслийн Институт зэрэг байгууллагууд руу хамтран ажиллах саналыг цахим шуудангаар хүргүүлсэн боловч одоогоор хариу хүлээж аваагүй байна.



Зураг-3.19

3.3 АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН УР ЧАДВАР, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА САХИЛГЫГ ӨНДӨРЖҮҮЛЭХ, ЁС ЗҮЙГ САХИХ ЧИГЛЭЛЭЭР САНААЧИЛЖ ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮН

- Хөдөлмөрийн дотоод журмын 13 бүлгийн 118 заалтын хэрэгжилт, албан хаагчийн ёс зүйн дотоод дүрмийн 4 бүлгийн 21 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Хөдөлмөрийн дотоод журмын 15.2.3 заасны дагуу
 - ХТХ-ийн мэргэжилтэн Э.Энхтуулд буцалтгүй тусламж
 - ЭЗСХ-ийн мэргэжилтэн Б.Цэрэнтогтоход буцалтгүй тусламж
 - ХТХ-ийн ахлах мэргэжилтэн Ш.Баяржавхланд буцалтгүй тусламж
 - ЗМХ-ийн дарга Л.Эрдэнэбатад буцалтгүй тусламжийг захиргааны зөвлөлийн хурлын шийдвэр,
 - ЗМХ-ийн тооцооны нягтлан бодогч Д.Солонго,
 - АТХ-ийн ахлах мэргэжилтэн Н.Мөнхзул нарт шинэ хүүхэд мэндэлсэний тэтгэмжийг дотоод журмыг үндэслэн даргын Б тушаалаар олгосон.
- Хүүхэд асрах чөлөөтэй байсан архитектор Б.Их-Аз 02 дугаар сарын 27-ны өдрийн Б/24 дугаар тушаалаар, ЗМХ-ийн дотоод ажил тогтоол шийдвэрийн мэргэжилтэн Б.Тэнгэрцэцэг 06 дугаар сарын 06-ны өдрийн Б/74 дугаар тушаалаар, Ахлах мэргэжилтэн Д.Даваажаргал 11 дүгээр 01-ний өдрөөс Б/123 дугаар тушаалаар ажилдаа эргэн орж ажиллаж байна.
- 2023 оны жилийн эцсийн байдлаар албан томилолтоор явсан 16 албан хаагчдад томилолтын хуудас бичиж олгон, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан.
- ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шагнал урамшуулал олгох журмын дагуу улирал бүр ажилтнуудын ажлыг гүйцэтгэлийг үнэлэн даргын тушаалаар нэмэгдэл олгодог болов.
- Байгууллагын хүний нөөцийн Б/тоот тушаалууд гуравдугаар улирлын байдлаар 134 тушаал төлөвлөж батлуулсан байна.

3.3.1 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд

Байгууллагын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсруулан гаргаж байгаа хот төлөвлөлт, зураг төслийн баримт бичгийн чанар стандартыг дээшлүүлэх зорилтын дагуу MNS ISO-9001:2016 буюу Чанарын удирдлагын тогтолцоо шаардлага стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сараас 2022 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл зохион байгуулж дараах 4 бүлэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

1. Сургалт, бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагаа зохион байгуулсан.
-

Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд байгууллагын удирдах багийн 18 ажилтнуудыг MNS ISO-9001:2016 стандартын анхан шатны мэдлэг олгох, таниулах сургалтад хамруулан гэрчилгээ авсан.

Байгууллагын үйл ажиллагаанд “Чанарын удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлэхэд бэлтгэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавих чиг үүрэг бүхий удирдлагын багийг байгууллагын даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/80 дугаар тушаалаар томилж байгууллагын бодлого, эрхэм зорилго, зорилгод хүрэхэд шаардагдах үйл явц болон арга хэмжээг тогтоох, эрсдэлийг үнэлэн нөөцийг тодорхойлон ажилласан.



Зураг-3.20

2. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулж боловсронгуй болгох.

Байгууллагын даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/43 дугаар тушаалаар “Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх удирдлагын баг”, “Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх зөвлөх баг”-ийг тус тус томилсон.

Тогтолцоог хэрэгжүүлэх зөвлөх баг нь:

- ISO-9001 стандартын шаардлагын үндсэн элементүүдийг бий болгох,
- шаардлагатай бичиг баримт, журмуудыг боловсруулах,
- хянаж сайжруулах,
- тогтолцоог хэрэглэх хэвшүүлэх,
- стандартын сан бүрдүүлэх,
- стандартын сургалт, судалгааг авах,
- нийт ажилтнуудыг идэвхжүүлж мэдээлэл хүргэх

зорилтот үйл ажиллагаануудыг тусгасан төлөвлөгөөг боловсруулан 9 сарын хугацаанд үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай үйл явцын схемүүдийг гаргаж холбогдох дүрэм, журам, заавар, аргачлал зэрэг нийт 37 баримт бичиг буюу “Хөдөлмөрийн дотоод журам”, түүнийг үндэслэн батлагдсан дүрэм, журмууд болон Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой дүрэм, журмуудыг тус тус боловсруулан баталгаажуулсан.

Үүнд:

- Нэг. 1 “Чанарын менежментийн тогтолцоо”-ны журмууд -7
- Нэг. 2 “Үйлдвэрлэл”-ийн журмууд, үндсэн үйл явцын схемүүд -8
- Нэг. 3 “Удирдах үйл явц”-ын журмууд -7
- Нэг. 4 “Дэмжих үйл ажиллагаа”-ны журмууд -10

- Хоёр. Дүрэм -2
- Гурав. Заавар -2
- Дөрөв. Аргачлал

Мөн байгууллагын үйл ажиллагаанд ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх арга зүйн удирдамжийн баримт бичиг болох “Чанарын гарын авлага” боловсруулж гаргасан.

Байгууллагын хэрэгцээнд зориулан “Байгууллагад мөрдөгдөж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний баримт бичгүүд”-ийг мөрдөж ажиллах хүрээнд стандартын шаардлагын дагуу нэгтгэн хэвлэмэл материал /ном/ болгон ашиглаж байна.



Зураг-3.21

3. Дотоод аудитын тогтолцоог бий болгох.

Стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгөөний дагуу 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “ISO-9001:2015 стандартын дотоод аудитор” бэлтгэх сургалтыг зохион байгуулж чанарын менежментийн дотоод аудит хийх эрх бүхий гэрчилгээг 12 ажилтан хүлээн авсан.

Чанарын стандартын дотоод зөвлөх багтай хамтран 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгууллагын хүрээнд хэлтсүүдийн үйл ажиллагаанд чанарын менежментийн дотоод аудит хийх буюу дадлага (практик) сургалт зохион байгуулсан.

Аудитын үр дүнд хүний нөөцийг чадавхжуулах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, боловсруулж буй зураг төсөл, судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэж байгаа төслийн багийн үйл ажиллагааг оновчтой удирдах, үйл ажиллагааны цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэн ашиглах ажлуудыг хийсэн.

2022 оны 12 сарын 26-ны өдрийн байгууллагын даргын А/68 дугаар тушаалаар “ISO-9001 стандартын дотоод аудиторын баг”-ийг 12 гишүүн, байгууллагад мөрдөгдөх дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, засаж сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах үүрэгтэй баталсан.



Зураг-3.22



Зураг-3.23



Зураг-3.24

4. Баталгаажуулалт хийлгэх.


ISO-9001 стандарт нэвтрүүлж хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаанд мөрдлөг болгох “Байгууллагад мөрдөгдөж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний баримт бичгүүд”-ийг байгууллагын даргын 2022 оны 12 сарын 26-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталж олон улсын чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх зорилттой ажиллаж байна.

2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр байгууллагын нийт ажилтнуудад байгууллагын үйл ажиллагаанд ISO-9001:2015 стандарт нэвтрүүлж хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх зөвлөх баг”-ийн хийсэн ажлуудыг танилцуулах, “ISO-9001 стандартын гэрчилгээ” авахад бэлтгэх танилцуулга сургалтыг зохион байгуулсан.

Танилцуулга сургалтын агуулга:

- “Чанарын гарын авлага” танилцуулах,
- “Хөндлөнгийн аудитад хамрагдах үед анхаарах асуудал”.
- “Стандарт, хэмжилзүйн газар”-т баталгаажуулалтын гэрчилгээ авах хүсэлтийг хүргүүлэх.

Баталгаажуулалт авах дээрх хүсэлтийн дагуу 2023 оны 04 сарын 12-оос 14-ны өдрүүдэд “Стандарт, хэмжилзүйн газар”-аас чанарын удирдлагын тогтолцооны тохирлын шинжилгээ хийх үүрэг бүхий 2 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг анхдагч аудит хийсний үр дүнд, байгууллагын үйл ажиллагааны чиглэлд үл тохирлын тохиолдолгүйгээр үнэлэгдэн ISO-9001:2015 олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлэн “Чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ”-г хүлээн авсан.



Зураг-3.25

“Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа MNS ISO-9001:2016 Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг бүрэн нэвтрүүлж хэрэгжүүлснээр байгууллагын стратеги, үйл ажиллагааны эрсдэлийг тооцох, бодлого хэрэгжүүлэх, үйл ажиллагааны чанарыг сайжруулах, хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангах зорилготой ажиллаж байна.

3.3.2 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, холбогдох журмын хэрэгжилт

Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирүүлсэн 1 өргөдөл, алба хаагчдаас ирүүлсэн 59, нийт 60 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, программд бүртгэж, Захиргаа, менежментийн хэлтсээс хариуг 100% хугацаанд нь өгч ажиллаа.

Хэлтсийн нэр	Өргөдөл гомдлын тоо	Хугацаанд нь шийдвэрлэсэн	Шийдвэрлэх шатанд
Захиргаа менежментийн хэлтэс	59	56	3
Хот төлөвлөлтийн хэлтэс	1	1	-

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, зөрчлийг багасгах арга хэмжээг үе шаттайгаар авч ажиллаж байна.

Үүнд:

- 2023 онд шинээр ажилд орсон албан хаагчдад “ЕВР системийн өргөдөл, гомдлын дэд системтэй холбогдож ажиллах” заавар өгч цаашид хэрхэн шилжүүлэх, шийдвэрлэх, шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар заавар, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.
- 2023 оны 4-р улирлын байдлаар иргэд, албан хаагчаас ирүүлсэн нийт 60 өргөдөл, гомдлыг нэгдсэн программд бүрэн бүртгэж, Хот төлөвлөлтийн хэлтсийн даргад холбогдох өргөдөл, гомдлыг хугацаанд нь багтаан шийдвэрлэх заавар, зөвлөмж хүргүүлэв.
- Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх явцад өдөрт нь багтаан шийдвэрлээгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй зэрэг зөрчил гарсан байна. Холбогдох албан хаагчид цаашид зөрчил гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4. 2023 оны 04 дүгээр улирлын байдлаар ажилтны буруутай үйлдлээс болж өргөдлийг хугацаандаа шийдвэрлээгүй, иргэнд хүндрэл учруулсан албан хаагч байхгүй




Зураг-3.26

Ажилтнуудын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал

2023 оны 4-р улирлын байдлаар Иргэдээс болон албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх чиг үүрэг бүхий 5 албан хаагч ажилласан байна.


Захиргаа удирдлага санхүүгийн хэлтэс	Нийт	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Бүгд	Хугацаа хэтэрсэн	Хугацаандаа байгаа	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн	Бүгд
Д.Нарантуул	100%	21	0	0	21	0	21
Ш.Ариунгэрэл	100%	19	0	0	19	0	19
Б.Тэнгэрцэцэг	100%	1	0	0	1	0	1
Т.Тэлмэн	100%	1	0	0	1	0	1
И.Пүрэвжав	100%	18	0	3	15	0	18
НИЙТ	100%	60	0	3	57	0	60



Зураг-3.27

3.4 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ОЛОЛТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ ШУУРХАЙ БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ, ҮР ДҮН

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтад заасны дагуу Мэдээлэл хариуцагч нь өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах заалтын хүрээнд байгууллагын цахим сайтад мэдээллийг шинэчлэн оруулж эхний хагас жилийн мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/253 тоот албан бичгээр хүргүүлсэн.



Зураг-3.28

Шилэн дансны цахим хуудсанд shilendans.gov.mn санхүү, хүний нөөцийн ил тод байдал, нийтийн албанд Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэргийн мэдээллийг холбогдох хуулийн хугацаанд нь оруулан ажиллаж байна. Шилэн дансны мэдээлэлд хугацаа хэтэрч оруулсан мэдээлэл 2 байна.

Үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд чиг үүрэг, зохион байгуулалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын үйл ажиллагааны тайлан зэргийг тухай бүр байгууллагын сайтад байршуулсан.

Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд ажлын байр, албан хаагчдын мэдээлэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, Төрийн албаны зөвлөлийн төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай зөвлөмж, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Байгууллагын ёс зүйн дүрэм батлах тухай даргын тушаал, сул орон тооны зарыг,

Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, тендерийн мэдээлэл, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын тайлан, төлөвлөгөө, биелэлт зэрэг мэдээллийг байршуулаад байна.

Хүснэгт-3.2. Ил тод байдлын шалгуур үзүүлэлт

	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Институтийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны А/08 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөн. Тушаалын хавсралтыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100 хувь
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнтэй холбоо барих мэдээлэл, иргэдийг хүлээж авах цагийн хуваарийг байгууллагын http://upri.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	100 хувь
3.	Сар бүрийн эхэнд шилэн дансанд мэдээлэл оруулах	Тухай бүр хугацаанд нь хийж ажиллаж байна.	100 хувь

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Байгууллагад гарсан сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулсан, мөн Зангиа.мн-д байршуулан ажил горилогчийн анкетыг бүрдүүлж удирдлагын түвшинд танилцуулан ажиллаж байна.	100 хувь
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг ISO 9001 чанарын стандартын хүрээнд шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.	100 хувь
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	95 хувь

3.5 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Институтийн даргын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагч нарт үүсэж хөтлөгдсөн 2022 оны баримтуудыг 87 заалтаар 231 баримтыг Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Архивын газрын даргын 2010 оны А/36 дугаар тушаал “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын тоон тайлан, баримтын мэдээ гаргах журам”, 2021 оны Стандарт хэмжил зүйн газрын баталсан MNS 5140:2021 стандарт, Институтийн даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/63 дугаар тушаал “Архивын үйл ажиллагааны журам”-ын дагуу хүлээн авч баталгаажуулах ажил явагдаж байна.

Цахим архивын сан үүсгэх ажлын хүрээнд “Рааш булаг”-аас Нийслэлийн төр захиргааны цогцолбор байр луу 2022 оны 09 дүгээр сарын 20-нд нүүлгэх ажлыг зохион байгуулж 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 4 гэрээт ажилтан авч цахимжуулах ажлыг эхлүүлсэн ба Архивын ерөнхий газрын зураг төслийн архивын мэргэжилтэн Н.Мядагмаа мэргэжилтний зөвлөсний дагуу нийт 2640 зураг төслийн баримтуудыг нарийвчлалтайгаар хянаж, шинээр хүснэгт гарган зохион байгуулалт – он цагийн шинж, газарзүйн байрлал, хот, дүүрэг, хороо болон холбогдох сэдвүүдээр бүлэглэн дараалалд оруулж, шинээр дугаарласан.

Төлөвлөгөөний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн цаасан материалуудыг цахимжуулах ажлыг эхлүүлж 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр бүрэн дуусгасан.



Зураг-3.29

Архивын лавлагаа мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сараас 2023 оны 03 дугаар сарын 17-ны хооронд байгууллагын архивыг цахимжуулж дууссан. Иргэдийн хүссэн лавлагаа мэдээллийг шуурхай хүргэж байна.

3.5.1 Нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд

Төрийн архивд шилжүүлэх 2014-2021 оны Байнга хадгалах 329 ХН-д эрдэм шинжилгээ, техник боловсруулалтыг хийж архивын хувийн хэрэг нээн байгууллага дээрээ байнга хадгалах 35 ХН, байгууллага дээрээ байнга хадгалах байгууллагын даргын гаргасан “А”, “Б” тушаал бүртгэлийн дэвтрүүд 17 ХН, Захирамжлалын цахим баримтын бүртгэл байгууллагын даргын гаргасан “А”, “Б” тушаалыг CD дээр PDF - ээр цахим хэлбэрт шилжүүлэн 611 MB хэмжээтэй 17 ХН-ийг шинээр төрөлжүүлэн гаргалаа.

Төрийн архивд шилжүүлэх Байнга хадгалах 2014-2021 оны нийт 238 хадгаламжийн нэгж бэлэн болсон байна.

1998 оноос эхэлсэн 2021 оны байдлаар Зураг төслийн байнга хадгалах 2640 Баримтуудыг нарийвчлалтайгаар хянаж, шинээр хүснэгт гарган зохион байгуулалт – он цагийн шинж, газарзүйн байрлал, хот, дүүрэг, хороо болон холбогдох сэдвүүдээр бүлэглэн дараалалд оруулж, шинээр дугаарлан шинэ бүртгэл хийсэн.

Нийт 2731 хадгаламжийн нэгжийг задалж, сканердаж, буцаан үдэж шинээр дугаарлан хайрцагласан, сканердсан бүх хадгаламжийн нэгжийн файлуудаа хард диск руу хуулсан байна.

Нийт А4-128,216 хуудас, А3-58,500 хуудас, А2-2087 хуудас, А1-1789 хуудас, А0-250 хуудас баримтуудыг сканердаж хадгаламжийн нэгжүүдийг задлан хуучирч муудсан хавтас, нуруу, нүүр зэргийг шинэчилж бүртгэлд оруулан архивын цахим мэдээллийн сан бүрдүүлэн аж.иллаа.

3.5.2 Нийслэлийн архивын газрын цахим нөхөн бүрдүүлэлтийн чиглэлээр

2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримтын /Тогтоол, Захирамж, Тушаал/ цахим нөхөн бүрдүүлэлтийн нийслэлийн дотоод удирдлагын “UB ERP” системээр дамжин нэвтэрч “Archive eDoc” байгууллагын даргын гаргасан үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан “А” тушаал 68, боловсон хүчний чиглэлээр гаргасан “Б” тушаал 140 нийт 208 тушаалуудыг бүртгэн оруулж Нийслэлийн архивын газраар хянуулан нягтлан шалгалт хийлгэсэн.

The screenshot shows the Archive eDoc web application interface. At the top, there are navigation tabs for '734', '87 2015', and '1518'. Below these are search filters and a table of data. The table has columns for 'Хүснэгт', 'Хугацаа', 'Хугацаа', 'Датум', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа', 'Хугацаа'. The table contains multiple rows of data, including document numbers and dates.

Зураг-3.30

3.5.3 Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 427 албан бичиг ирсэн байна. Үүнийг задлаж тайлагнавал:

1. Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо-117
 2. Системээр бүртгэгдсэн бичгийн тоо-310
 3. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр-0
- Үүнээс:
1. Хариутай бичиг-92
 2. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 93,96
 3. Хариугүй бичгийн хаалтын хувь 99.37,
 4. Нийт ирсэн бичгийн хувь 95.04,
 5. Шийдвэрлэлтийн дундаж 6.26 хоног гэсэн индексстэй байна
 6. Шийдвэрлэлтийн дундаж 6.53 хоног гэсэн индексстэй байна

2023 оны 12 дугаар сарын 11 19:54

Улаанбаатар хот

Д/д	Хэлтсийн нэр	Бүртгэгдсэн байдал						Хуваарилалт		Шийдвэрлэлтийн байдал								Хяналтын байдал														
		Энэ зууварын ирсэн бичигийн тоо (А1-А2-А3)		Нийслэлийн үйлчилгээний төвд ирсэн бичиг		Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо		Сэтгэхүү бүртгэгдсэн бичгийн тоо		Хувиарласан бичгийн тоо		Хувиарлагдаагүй бичгийн тоо		Үүлсө хариугай бичгийн тоо В-В1-В2-В3-В4		Хувиарлаагүй шийдвэрлэсэн				Хугацаанд хэтрэсэн				Хугацаа хэтрэсэн								
		А	А1	А2	А3	А4	А5	В	В1	В2	В3	В4	В5	В6	В7	В8	В9	В10	В11	В12	В13	В14	В15	В16	В17	В18	В19	В20	В21	В22	В23	В24
1	0. Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтэс	54	0	21	33	54	0	6	6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	100.00	48	46	0	0	2	100.00	100.00	1.69
2	1. Удирдлага	2	0	1	1	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	100.00	2	2	0	0	0	100.00	100.00	14.50
3	2. Захиргаа менежментийн хэлтэс	163	0	17	146	163	0	33	49	4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	96.23	110	104	0	0	6	100.00	96.98	4.96
4	3. Хот төлөвлөлтийн хэлтэс	33	0	11	22	33	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	100.00	32	29	0	0	3	100.00	100.00	12.06
5	4. Дэд бүтцийн хэлтэс	52	0	22	30	52	0	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	100.00	50	45	2	0	3	97.87	99.57	7.21
6	5. Эдийн засаг, судалгааны хэлтэс	32	0	15	37	32	0	15	13	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	93.33	37	36	1	0	0	98.65	94.39	6.75
7	6. Архитектур төлөвлөлтийн хэлтэс	29	0	16	13	29	0	6	5	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	91.67	23	22	0	0	1	100.00	93.34	8.66
8	7. Хотын дизайны хэлтэс	12	0	1	11	12	0	3	1	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	66.67	9	8	1	0	0	94.44	72.22	15.33
9	8. Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс	21	0	9	12	21	0	5	3	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	80.00	16	16	0	0	0	100.00	84.00	7.38
	Нийт	418	0	113	305	418	0	91	80	11	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	93.96	327	308	4	0	15	99.36	95.04	6.32

Зураг-3.31

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 548 бичиг явуулсан байна. Үүнийг задлаж тайлагнавал:

1. Захиргаа, менежментийн хэлтэс-230
2. Хот төлөвлөлтийн хэлтэс-30
3. Архитектур төлөвлөлтийн хэлтэс-36
4. Дэд бүтцийн хэлтэс-77
5. Хотын дизайны хэлтэс-13
6. Эдийн засгийн судалгааны хэлтэс- 82
7. Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс-28
8. Зам тээвэр, судалгааны хэлтэс- 82 бичиг явуулсаныг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж хүргүүллээ.

ЯВУУЛСАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

/2023.01.01-2023.10.02/

2023 оны 10 сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Хэлтэс нэгж	Нийт	Хариугай	Хариугүй	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хугацаа хэтрүүлж хариу ирүүлсэн	Шийдвэрлэх шатандаа	Хугацаа хэтэрсэн, хариу ирээгүй	Шийдвэрлэлтийн хувь
Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ									
Нийслэлийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/									
1	Архитектур төлөвлөлтийн хэлтэс	22	0	22	0	0	0	0	100.00%
2	Дэд бүтцийн хэлтэс	58	1	57	0	0	0	0	100.00%
3	Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтэс	22	0	22	0	0	0	0	100.00%
4	Захиргаа менежментийн хэлтэс	185	0	185	0	0	0	0	100.00%
5	Хот төлөвлөлтийн хэлтэс	28	0	28	0	0	0	0	100.00%
6	Хотын дизайны хэлтэс	12	0	12	0	0	0	0	100.00%
7	Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс	21	0	21	0	0	0	0	100.00%
8	Эдийн засаг, судалгааны хэлтэс	65	0	65	0	0	0	0	100.00%
	Байгууллагын нийт	413	1	412	0	0	0	0	100 %

Зураг-3.32

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж, яаралтай шийдвэрлэх болон хариу шаардлагатай бүх бичгийг хяналтанд

авах, шийдвэрлэсэн баримтыг хяналтаас хасах, баримт бичгийн гүйцэтгэлийн явц, үр дүнг тооцох, мэдээ тайлан гаргаж ажилласан.

3.5.4 Тамга тэмдэг ашиглалт, хамгаалалтын хүрээнд

- Байгууллагын тамга тэмдгийг тогтсон журмын дагуу бат бөх цоожтой сейфэнд хадгалах, бусдад дамжуулахгүй байх зэрэг хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, Байгууллагын хэмжээнд байгууллагын тэмдэг 1ш, хуулбар үнэн тэмдэг 1, боловсруулсан дардас 1 ширхэг, ирсэн бичиг бүртгэх тэмдэг 1 ширхэгийг тус тус хэрэглэж, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаж байна.

Бичиг, баримтын бүрдлийг шалган, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж удирдлагын гарын үсэг зурагдан зөвшөөрөгдсөн тохиолдолд тамга дарж ажилласан.

3.6 ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

1. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/01 баталсан хуваарийн дагуу 1 дүгээр сарын 13-ны өдөр "Ердөө-90 минут" бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцож, хариуцсан талбайн цас мөсийг арилган иргэдийн аюулгүй зорчих нөхцлийг ханган ажилласан.



Зураг-3.33

2. 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Сар шинийн баярын өмнөх бүх нийтийн их цэвэрлэгээ”-нд хамт олноороо оролцов.



Зураг-3.34

3. 2023 оны 04 дүгээр сарын 10-ны 09:00 цагт “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ”, “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт танхимын сургалтад байгууллагын нийт ажилтнууд хамрагдсан.



Зураг-3.35

4. 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот – Иргэний оролцоо” хаврын мод тарих аяны хүрээнд Налайх дүүрэгт мод тарьсан.



Зураг-3.36

- 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар марафон-2023 олон улсын гүйлтэд нийт 11 албан хаагч амжилттай оролцсон.



Зураг-3.37

- 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт Улс даяар хамрагдах “Гамшгийн дуут дохиогоор зарлан мэдээлэх” сургалтад байгууллагын нийт ажилтнууд амжилттай хамрагдсан. Сургалтаар гэнэтийн газар хөдлөлт, осол аваараас хэрхэн өөрийгөө сэргийлэх, амь насаа хэрхэн аврах талаар анхан шатны мэдлэгүүдийг олж авсан.



Зураг- 3.38

7. Хот төлөвлөлт, судалгааны институтийн хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдөр "Цусны донорын өдөрлөг" сайн үйлсийн аянд нэгдэж цусаа хандивлах аянд байгууллагын хамт олон идэвхтэй оролцсон.



Зураг-3.39

8. 2023 оны 09 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Хотын стандарт, хяналтын газраас зохион байгуулсан “Иргэдэд ээлтэй стандарт” өдөрлөгт оролцсон.



Зураг-3.40

9. 2023 оны 09 дүгээр сарын 16-ний өдөр “Эх дэлхийн цэвэрлэгээний өдөр”-т нэгдэж, бүх нийтийн их цэвэрлэгээнд хамрагдаж Энхтайваны гүүрнээс Нарны гүүр хүртэлх Дунд голын зам дагуу хогийг түүж цэвэрлэлээ.



Зураг-3.41

10. Энэ оны 10 сард зохион байгуулагдсан “Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын Спортын V наадам”-ын хүрээнд ажлын байрны дасгал хөдөлгөөн төрөлд ахлах мэргэжилтэн Д.Хулан оролцсон бөгөөд тус тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож сагсан бөмбөгийн төрөлд 3-р байр эзсэн.



Зураг-4.42



Зураг-3.43

11. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Яармаг дах Төр захиргааны цогцолбор байрны гадна талбайн 50 метрийн радиуст байх нийтийн эзэмшлийн явган хүн, авто замын цас мөс цэвэрлэгээний ажлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулан ажиллалаа.



Зураг-3.44, 3.45

12. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан “Цасаа цэвэрлэе” аяны удирдамжийн дагуу Яармаг дах Төр захиргааны цогцолбор байрны орчны 50 метрийн радиуст байх нийтийн эзэмшлийн явган хүн, авто замын цас мөс

цэвэрлэгээний ажлыг батлагдсан хуваарийн дагуу 2023 оны 12 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулан ажиллалаа.



Зураг-3.46

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ЗАХИРГАА, МЕНЕЖМЕНТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД АЖИЛ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Ариунгэрэл* Ш.АРИУНГЭРЭЛ



Р.АМАРТҮВШИН

А.БАТТӨМӨР

Л.ЭРДЭНЭБАТ